

ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН ГЭРЭЭ

Огноо: 2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр

Гэрээний Талууд:

1. **Эрдэнэс МГЛ ХХК** - Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан Төрийн өмчит компани (цаашид “**ТӨК**” гэх).
2. **Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд** - 9 Колумбус Центр Билдинг, Роуд Таун, Тортола, Британийн Виржинийн Арлууд гэх хаягт байрлах, Британийн Виржинийн Арлуудын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид “**АйВиЭн**” гэх).
3. **Оюу Толгой Нидерланд Би.Ви** - Принс Бернхардплэйн 200, 1097 ЖиБи, Амстердам, Нидерланд гэх хаягт байрлах, Нидерланд Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид “**ОТН**” гэх).
4. **Айвенхоу Майнз Монголия Инк ХХК** - Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан компани (цаашид “**Компани**” гэх).

Ерөнхий зүйл

Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдөр Компанийн Хувь нийлүүлэгчид нь АйВиЭн болон ОТН байна. Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрөөс хойш АйВиЭн болон ОТН нь Компани дахь хувь эзэмшлийн бүтцээ өөрчилнө. ТӨК нь Гүйцэтгэлийн өдрөөс эхлэн Компанийн Хувь нийлүүлэгч болох бөгөөд ТӨК, АйВиЭн болон ОТН нь Компанийн Хувь нийлүүлэгчдийн хувьд Гүйцэтгэлийн өдөр болон түүнээс хойшхи хугацаанд эрх, үүргээ тодорхойлохын тулд энэхүү Гэрээг байгуулав.

Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдөр Монгол Улсын Засгийн газар болон Компани, Айвенхоу Майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитед Оюу Толгой Төслийг хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах нөхцөл, болзлыг зохицуулах зорилгоор Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулсан болно.

SHAREHOLDERS' AGREEMENT

Date: October 6, 2009

Parties:

1. **Erdenes MGL LLC**, a State owned company, duly incorporated under the Company Law of Mongolia (*SHC*).
2. **Ivanhoe Oyu Tolgoi (BVI) Ltd**, a body corporate, duly incorporated under the laws of the British Virgin Islands and having an office at 9 Columbus Centre Building, Road Town, Tortola, British Virgin Islands (*IVN*).
3. **Oyu Tolgoi Netherlands B.V.**, a body corporate, duly incorporated under the laws of The Netherlands and having an office at Prins Bernhardplein 200, 1097 JB, Amsterdam, The Netherlands (*OTN*).
4. **Ivanhoe Mines Mongolia Inc LLC**, a body corporate, duly incorporated under the Company Law of Mongolia (the *Company*).

Recitals

IVN and OTN are the Shareholders in the Company at the date of this Agreement. After the date of this Agreement, IVN and OTN intend to restructure their shareholding in the Company. SHC will become a Shareholder in the Company on the Completion Date, and SHC, IVN and OTN wish to enter into this Agreement in order to regulate their rights and obligations as Shareholders of the Company on and from that date.

On the date of this Agreement, the Government of Mongolia and the Company, Ivanhoe Mines Ltd and Rio Tinto International Holdings Limited entered into an Investment Agreement, to regulate the terms and conditions under which the development and operation of the OT Project will occur.

| | |
|---|---|
| <p>1. Нэр томъёоны тодорхойлолт</p> <p>Энэхүү Гэрээнд хэрэглэсэн нэр томъёог энэ Гэрээний 24 дүгээр зүйлд заасны дагуу ойлгоно.</p> | <p>1. Definitions</p> <p>The definitions set out in clause 24 shall apply in this Agreement.</p> |
| <p>2. Гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл</p> <p>Талууд энэхүү Гэрээг болон энэхүү Гэрээгээр хүлээх үүрэг (энэ 2 дугаар зүйл болон 3.3(г) (Гэрээний гүйцэтгэлийн үүрэг), 16 дугаар зүйл (Мэдэгдэл ба баталгаа), 22 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх), 23 дугаар зүйл (Бусад зүйл)-д зааснаас бусад)-ээ гэрээ Хүчин төгөлдөр болох өдөр хүртэл заавал биелүүлэх үүрэг хүлээхгүй.</p> | <p>2. Conditions Precedent</p> <p>This Agreement and the obligations of the Parties under this Agreement (other than this clause 2 and clauses 3.3(d) (Completion obligations), 16 (Representations and warranties), 22 (Dispute resolution) and 23 (Miscellaneous)) do not become binding on the Parties unless and until the Effective Date occurs.</p> |
| <p>3. Компанийн хувь эзэмшлийн бүтэц</p> <p>3.1 Төрийн эзэмшлийн хувьцаа - 34 хувь</p> <p>Гүйцэтгэлийн өдөр ТӨК Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Компанийн Хувьцааны 34 (гучин дөрөв)-н хувийг энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу ямар нэг Барьцаагүйгээр эзэмшинэ. ТӨК-ийн Эзэмшлийн энэ хувь хэмжээг өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд аливаа шинэ Хувьцаа гаргах замаар бууруулж болохгүй.</p> <p>3.2 Хувьцаа гаргах</p> <p>(a) Хөрөнгө оруулалтын гэрээнд Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж (Ашигт малтмалын тухай хууль болон Тогтоолын дагуу) гарын үсэг зурагдснаар Компани нь Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу Оюу толгой төсөлд Монгол Улсын Засгийн газрын оруулах хувь нэмрийг харгалзан Төрийн эзэмшлийн хувьцааг гаргаж ТӨК-д шилжүүлэхээр зөвшөөрөв.</p> <p>(б) Компани нь Төрийн эзэмшлийн хувьцааг Гүйцэтгэлийн өдөр энэхүү Гэрээнд заасан нөхцөлийн дагуу гаргаж ТӨК-д</p> | <p>3. Equity structure of Company</p> <p>3.1 Government Issue Shares – 34%</p> <p>On the Completion Date, SHC, on behalf of the Government of Mongolia, shall hold 34% of the Company’s Shares free from all Pledges on the terms set out in this Agreement. Such Percentage Interest of SHC shall not be diluted without its consent, by the issue of any new Shares.</p> <p>3.2 Share issue</p> <p>(a) As consideration for the contribution to be made by the Government of Mongolia to the OT Project under the Investment Agreement, upon the Investment Agreement being signed by and on behalf of the Government of Mongolia (in accordance with the Resolution and the Minerals Law), the Company agrees to issue the Government Issue Shares to SHC in accordance with this Agreement.</p> <p>(b) The Company shall issue the Government Issue Shares to SHC on the Completion Date on the terms set out in this Agreement. All existing Shareholders agree not to exercise their right to pre-empt the issue of the Government Issue Shares issued in accordance with this</p> |

шилжүүлнэ. Одоогийн бүх Хувь нийлүүлэгчид энэхүү Гэрээний 3-д заасны дагуу гаргасан Төрийн эзэмшлийн хувьцааны хувьд хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэхгүй байхыг зөвшөөрч байна.

3.3 Гэрээний гүйцэтгэлийн үүрэг

- (a) Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 14 (арван дөрөв)-н хоногийн дотор Компани нь Төрийн эзэмшлийн хувьцааг Гүйцэтгэлийн өдөр гаргаж ТӨК-д эзэмшүүлэх шийдвэр гаргана;
- (б) Төрийн эзэмшлийн хувьцааг Гүйцэтгэлийн өдөр гаргаж ТӨК-д эзэмшүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүргийг Компани хүлээнэ;
- (в) Компани нь Гүйцэтгэлийн өдөр Улаанбаатар хотод дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ:
 - (i) Төрийн эзэмшлийн хувьцааг гаргаж ТӨК-д шилжүүлсэн тухай Компанийн бүртгэлд бүртгэх;
 - (ii) Төрийн эзэмшлийн хувьцааны гэрчилгээг ТӨК-д хүргүүлэх;
 - (iii) Төрийн эзэмшлийн хувьцааг гаргаж ТӨК-д шилжүүлснийг бүртгүүлэхтэй холбогдсон баримт бичгүүдийг Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Гадаадын хөрөнгө оруулалтын газарт тус тус хүргүүлэх.
- (г) Гүйцэтгэлийн өдрөөс өмнө ТӨК болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь энэхүү Гэрээний 4.3(a)-д заасны дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулах нэр дэвшигчдийнхээ тухай Компанид болон нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Тухайн нэр дэвшигчийг Гүйцэтгэлийн өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилогдсонд тооцно.

clause 3.

3.3 Completion obligations

- (a) Within not later than fourteen (14) days after the Effective Date, the Company must authorise the issue to SHC of the Government Issue Shares on the Completion Date.
- (b) The Company must do all things necessary to issue to SHC the Government Issue Shares on the Completion Date.
- (c) On the Completion Date, in Ulaanbaatar, the Company must:
 - (i) record in its books the issue of the Government Issue Shares to SHC;
 - (ii) deliver to SHC the share certificate in respect of the Government Issue Shares; and
 - (iii) lodge with the State Registration Agency and the Foreign Investment and Foreign Trade Agency documents recording the issue to SHC of the Government Issue Shares.
- (d) Before the Completion Date, SHC and the Ivanhoe Shareholders shall deliver written notice to the Company and each other nominating its Directors under clause 4.3(a). The nominated Directors will be considered as appointed on the Completion Date.

| | |
|---|---|
| <p>3.4 Гүйцэтгэлийн өдрийн ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ</p> <p>Төрийн эзэмшлийн хувьцаа гаргаж ТӨК-д шилжүүлснээр ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ нь Компанийн нийт Хувьцааны 34 (гучин дөрөв) хувь байна.</p> | <p>3.4 Percentage Interest of SHC as at Completion Date</p> <p>Immediately after the issue of the Government Issue Shares to SHC, the Percentage Interest of SHC in the Company will be 34%.</p> |
| <p>4. Компанийн үйл ажиллагаа ба удирдлага</p> <p>4.1 Компанийн үйл ажиллагааны хүрээ</p> <p>Компани нь хуулиар хориглоогүй аливаа үйл ажиллагааг эрхэлж болох бөгөөд Үндсэн үйл ажиллагаатай холбоотой үйл ажиллагаа явуулахад шаардлагатай эрх эдэлж, үүрэг хүлээнэ.</p> <p>4.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх</p> <p>Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь энэхүү Гэрээний 4.10(a)-д заасан Хувь нийлүүлэгчдийн хурлын онцгой эрхэд хамааруулснаас бусад Компанийн үйл ажиллагаатай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх эрхтэй.</p> <p>4.3 ТУЗ-ийн гишүүд</p> <p>(a) Гүйцэтгэлийн өдөр ТУЗ-ийн гишүүдийг томилохдоо ТӨК 3 (гурав), Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид 6 (зургаа)-н ТУЗ-ийн гишүүнийг энэхүү Гэрээний 4.3(б)-д заасны дагуу тус тус нэр дэвшүүлэх эрхтэй болохыг Талууд хүлээн зөвшөөрч байна.</p> <p>(б) Энэхүү Гэрээний 4.3(в)-д заасныг баримтлан 10 (арав) болон түүнээс дээш Эзэмшлийн хувь хэмжээтэй Хувь нийлүүлэгч бүр өөрийн Эзэмшлийн хувь хэмжээнд ногдох тоог 10 (арав)-г хуваасантай тэнцүү тооны хүнийг ТУЗ-ийн гишүүнд томилуулахаар тухай бүр шууд нэр дэвшүүлэх, чөлөөлөх эрхтэй. Энэхүү тооцоогоор гарах бутархай тоог ТУЗ-ийн гишүүдийн тоог тодорхойлоход тооцожгүй;</p> | <p>4. Business and management of Company</p> <p>4.1 Scope of Company business</p> <p>The Company may conduct any activities not prohibited by law and shall exercise rights and incur obligations necessary to conduct such activities as are related to Core Operations.</p> <p>4.2 Authority of Board of Directors</p> <p>The Board of Directors shall exercise authority with respect to all matters in connection with the Company, except for those matters reserved to the exclusive authority of a meeting of Shareholders under clause 4.10(a).</p> <p>4.3 Directors</p> <p>(a) The Parties acknowledge that, for the purpose of appointing members of the Board of the Directors on the Completion Date, SHC is entitled to nominate three Directors and the Ivanhoe Shareholders are entitled to nominate six Directors, in accordance with clause 4.3(b).</p> <p>(b) Subject to clause 4.3(c), each Shareholder having a Percentage Interest of 10% or more is entitled to directly nominate and replace from time to time, a number of Directors equivalent to the number of percentage points of its Percentage Interest divided by ten (10). Fractions in the number of Directors are to be disregarded in this</p> |

| | |
|--|---|
| <p>(в) Энэхүү Гэрээний 4.3(б)-д заасан Хувь нийлүүлэгчийн Эзэмшлийн хувь хэмжээг тодорхойлохдоо тухайн Хувь нийлүүлэгч болон түүнтэй Хамаарал бүхий компанийн эзэмшиж буй хувьцааг нэгтгэн тооцох бөгөөд ийнхүү нэгтгэсэн Эзэмшлийн хувь хэмжээ нь тухайн Хувь нийлүүлэгчдэд Гэрээний 4.3(б)-д заасан эрхийг хамтаар (нэг буюу түүнээс дээш тооны Хувь нийлүүлэгчээрээ төлөөлүүлэн) хэрэгжүүлэх эрх олгоно;</p> <p>(г) Энэхүү Гэрээний 4.3(б)-д заасны дагуу тухай бүр ТУЗ-ийн гишүүнд санал болгосон нэр дэвшигчдийг энэхүү Гэрээний 4.10(б)-д заасны дагуу Хувь нийлүүлэгчдийн дараагийн хурлаар томилох бөгөөд Хувь нийлүүлэгч бүр нөгөө талаас дэвшүүлсэн нэр дэвшигчийг дэмжсэн санал өгнө;</p> <p>(д) ТУЗ-ийн гишүүн бүр өөрийн түр эзгүйд, эсхүл өвчтэй байх хугацаанд болон бусад шалтгаанаар ТУЗ-ийн гишүүний үүргээ биелүүлж чадахгүй байх хугацаанд, түүнчлэн тодорхой нөхцөл байдал үүсэх хүртэл өөрийгөө орлох этгээдийг томилж болно. Уг томилолтыг бичгээр үйлдэж, тухайн томилж буй ТУЗ-ийн гишүүн гарын үсэг зурж хувийг нь Компанид хүргүүлнэ;</p> <p>(е) Хувь нийлүүлэгч нь ТУЗ-д өөрийн санал болгож томилуулсан ТУЗ-ийн гишүүнээ бусад Хувь нийлүүлэгчдэд мэдэгдсэнээр өөрчилж болох бөгөөд уг томилгоог Хувь нийлүүлэгчдийн хурлаар батална.</p> | <p>calculation.</p> <p>(c) For the purpose of determining a Shareholder's Percentage Interest under clause 4.3(b), the shareholding of the Shareholder and its Related Corporations will be aggregated and such aggregate Percentage Interest will confer upon such Shareholders collectively (acting through one or more of such Shareholders) the rights set out in clause 4.3(b).</p> <p>(d) The Directors nominated in accordance with clause 4.3(b) from time to time shall be appointed at the next meeting of Shareholders in accordance with clause 4.10(b), at which meeting each Shareholder agrees to vote in favour of the other Shareholders' nominated Directors.</p> <p>(e) Each Director may appoint any person to act as an alternate Director in the Director's place, either for a stated period or until the happening of a specified event, whenever by temporary absence or illness or otherwise the Director is unable to attend to duties as a Director. The appointment must be in writing and signed by the appointing Director and a copy of the appointment must be given to the Company.</p> <p>(f) With notification to the other Shareholders, a Shareholder may replace an appointed Director, and such appointment will be confirmed at a Shareholders' meeting.</p> |
| <p>4.4 Санал өгөх ТУЗ-ийн гишүүн бүр саналын 1 (нэг) эрхтэй байна.</p> | <p>4.4 Voting Each Director is entitled to one vote.</p> |
| <p>4.5 ТУЗ-д томилогдсон гишүүд ТУЗ-ийн гишүүн нь үүргээ биелүүлэхдээ Компанийн ашиг сонирхолд дээд зэргээр нийцүүлэн үнэнч шударгаар ажиллана. Компанийн ТУЗ-ын гишүүний хувьд ТУЗ-ийн гишүүн нь өөрийн үүргээ биелүүлэх, өөрт олгогдсон эрх мэдэл, давуу байдлаа хэрэгжүүлэхдээ өөрийг нь томилсон Хувь нийлүүлэгчийн ашиг сонирхлыг харгалзах үүднээс хандаж, түүний хүсэлд тулгуурлан үйл ажиллагаа явуулж болно.</p> | <p>4.5 Nominee Directors Provided that a Director acts in good faith in the best interests of the Company as a whole, a Director appointed by a Shareholder may take into account the interests of that Director's appointor and may act on the wishes of that appointor in performing any of his or her duties or exercising any power, right or discretion as a Director in relation to the Company.</p> |

4.6 ТУЗ-ийн хурал

- (a) ТУЗ-ийн хурлыг улиралд 1 (нэг) удаа хуралдуулна. Аливаа 3 (гурав)-н ТУЗ-ийн гишүүний хүсэлтээр түүнээс олон удаа хуралдуулж болно. Онцгой байдал үүссэнээс бусад тохиолдолд хамгийн сүүлийн хурлаас хойш 30 (гуч) хоногийн дотор дараагийн хурлыг хуралдуулахыг 3 (гурав)-н ТУЗ-ийн гишүүн шаардах эрхгүй. ТУЗ-ийн шийдвэрт өөрөөр заагаагүй бол:
- (i) ТУЗ-ийн бүх хурлыг Улаанбаатар хотод хийнэ;
 - (ii) ТУЗ-ийн хурлын зарыг гишүүдэд 21 (хорин нэг)-ээс доошгүй хоногийн өмнө хүргүүлнэ.

ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хурлыг видео конференс болон харилцаа холбооны ижил төрлийн шууд дамжуулах бусад технологийг ашиглан хийж болох бөгөөд уг хурлыг Улаанбаатар хотод хийсэнд тооцно.

- (б) ТУЗ-ийн хурлын зар мэдээнд тусгагдах ёстой бусад зүйлээс гадна тухайн хурлаар хэлэлцэх асуудал бүрийн талаарх зохих хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан хэлэлцэх асуудлыг тусгаж, холбогдох бусад баримт бичгийг хавсаргана. ТУЗ-ийн гишүүн бүр зөвшөөрч өөрөөр тохиролцоогүй бол ТУЗ-ийн хурлаар зөвхөн хэлэлцэх асуудалд тусгасан асуудлыг хэлэлцэнэ.
- (в) Хувь нийлүүлэгчид өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүний ТУЗ-ийн хуралд оролцохоор хүрэлцэн ирэх, буцах замын болон холбогдох бусад зардал, гишүүнийхээ үүргийг гүйцэтгэхтэй холбоотой бүх зардлыг хариуцна. Оюу толгой төслийн талбайд ТУЗ-ийн хурлыг хийх тохиолдолд Компани нь ТУЗ-ийн гишүүдийн Улаанбаатар хотоос очих, буцах тээвэр, байр, хоолны зардлыг хариуцна;
- (г) ТУЗ-ийн хуралд ТУЗ-ийн нийт гишүүний Дийлэнх олонхи (үүнд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон ТӨК-ийн томилсон тус бүр 1 (нэг)-ээс доошгүй гишүүн заавал оролцсон байх шаардлагатай) оролцсон (биечлэн, эсхүл өөрийгөө төлөөлүүлэн)-оор хурлын ирц бүрдэнэ. ТУЗ-ийн хурлын ирц бүрдээгүй тохиолдолд хурлыг хойшлуулахаас өөр асуудал хэлэлцэхгүй;

4.6 Meetings of Board of Directors

- (a) The Directors must meet quarterly or more frequently as requested by any three Directors (provided that three Directors cannot require a meeting to be held within 30 days of the most recent meeting, except in the case of an emergency). Unless otherwise agreed by resolution of the Board of Directors:
- (i) each meeting of the Board of Directors must be held in Ulaanbaatar; and
 - (ii) at least 21 days' notice must be given to each Director of all meetings of the Board of Directors.

The Board of Directors by its resolution may hold its meeting using video conferencing or similar instantaneous communication technology, provided such meeting is held in Ulaanbaatar.

- (b) Each notice of meeting must contain, among other things, an agenda specifying in reasonable detail the matters to be discussed at the relevant meeting and must be accompanied by any relevant papers for discussion at that meeting. Unless otherwise agreed by each of the Directors, a meeting of the Board of Directors may only resolve matters specifically described in the agenda.
- (c) Each Shareholder must bear all travelling and other expenses incurred by any Director appointed by it in attending and returning from meetings of the Board of Directors and performing his or her duties as a Director. The Company will supply or provide transport to and from Ulaanbaatar, accommodation and meals for Directors in respect of a meeting of the Board of Directors held at the OT Project site.
- (d) A quorum for a meeting of the Board of Directors is constituted by the attendance (in person or by alternate) of an Overwhelming Majority of the Directors (which must include at least one Director appointed by the Ivanhoe Shareholders and one Director appointed by SHC). No business is to be transacted at a meeting of the Board of Directors meeting unless a quorum is present, except for the

| | |
|--|---|
| <p>(д) ТУЗ-ийн хурлын ирц зар мэдээнд заасан хурал эхлэх хугацаанаас хойш 30 (гуч)-н минутын дотор бүрдээгүй тохиолдолд тухайн хурлыг 2 (хоёр) өдрөөр хойшлуулна. Хойшилсон хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж болохгүй. Хойшлогдсон хурлын ирц ТУЗ-ийн нийт гишүүний Дийлэнх олонхи хүрэлцэн ирснээр бүрдэнэ.</p> | <p>adjournment of the meeting.</p> <p>(e) If there is not a quorum at a meeting of Directors within 30 minutes after the time specified in the notice of meeting, the meeting will stand adjourned for two days. No changes may be made in the agenda for the adjourned meeting. There shall be a quorum at the adjourned meeting if an Overwhelming Majority of members of the Board of Directors are present.</p> |
| <p>4.7 ТУЗ-ийн дарга</p> <p>(a) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид өөрсдийн томилсон ТУЗ-ийн гишүүдийн дундаас нэг гишүүнийг ТУЗ-ийн даргаар томилж болно;</p> <p>(б) ТУЗ-ийн аливаа хуралд ТУЗ-ийн дарга хүрэлцэн ирээгүй бол Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид тухайн хурлыг удирдуулахаар өөрсдийн томилсон ТУЗ-ийн гишүүдийн дундаас 1 (нэг) гишүүнийг томилж болно;</p> <p>(в) ТУЗ-ийн хурал дээр аливаа асуудлаар ТУЗ-ийн гишүүдийн санал тэнцвэл ТУЗ-ийн дарга тухайн асуудлыг эцэслэн шийдвэрлэх саналын эрхтэй байна.</p> | <p>4.7 Chair</p> <p>(a) The Ivanhoe Shareholders may appoint one of the Directors appointed by them to be the Chair of the Board of Directors.</p> <p>(b) If the Chair of the Board of Directors is not present at any meeting of the Board of Directors, the Ivanhoe Shareholders may appoint one of their Directors to act as Chair for the purpose of that meeting.</p> <p>(c) The Chair of the Board of Directors has a casting vote in the event that there is a tied vote cast by the Directors on any matter.</p> |
| <p>4.8 ТУЗ-ийн шийдвэр</p> <p>ТУЗ-ийн хурлаас гарах аливаа тогтоол, эсхүл шийдвэрийг тухайн хуралд (биечлэн, эсхүл өөрийгөө төлөөлүүлэн) оролцож байгаа саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүдийн Дийлэнх олонхийн дэмжсэн саналаар гаргана.</p> | <p>4.8 Board of Directors' decisions</p> <p>Any resolution or decision of the Board of Directors must be made at a meeting of Directors by the affirmative vote of an Overwhelming Majority of votes of the Directors of the Company who are present (in person or by alternate) at the meeting and entitled to vote.</p> |
| <p>4.9 ТУЗ-ийн хороод</p> <p>ТУЗ шаардлагатай гэж үзвэл тухайлсан асуудал хариуцсан 1 (нэг) буюу хэд хэдэн ТУЗ-ын хороо байгуулж болно.</p> | <p>4.9 Board of Directors' committees</p> <p>The Board of Directors may constitute one or several committees of the Board of Directors which may be entrusted with any matter(s) which the Board of Directors determines to be appropriate.</p> |
| <p>4.10 Хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр</p> <p>(a) Энэхүү Гэрээний 4.2-т заасан Компанийн үйл ажиллагаатай</p> | <p>4.10 Shareholder approvals</p> <p>(a) All matters in connection with the Company are within the authority of the Board of Directors in accordance with clause 4.2, other than the matters set out below in this clause 4.10(a), which matters are within the authority of a meeting of Shareholders to consider and decide:</p> <p>(i) amendments to the Charter or the adoption of a new</p> |

| | |
|--|--|
| <p>холбоотой ТУЗ-ийн бүрэн эрхэд хамаарах бүх асуудлаас бусад буюу энэхүү Гэрээний 4.10(a)-д заасан дор дурдсан асуудлыг Хувь нийлүүлэгчдийн хурлын бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэж шийдвэрлэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (i) Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах; (ii) нийлэх, нэгдэх, хуваах, эсхүл өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах; (iii) Компанийн өрийг Хувьцаагаар солих; (iv) Компанийн хэлбэрийг өөрчлөх замаар Компанийг өөрчлөн байгуулах; (v) Компанийг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох; (vi) Компанийн Хувьцааг хуваах, эсхүл нэгтгэх; (vii) Энэхүү Гэрээний 5-д заасныг баримтлан Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах; (viii) ТУЗ-ийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох; (ix) Хянан шалгах зөвлөлийн гишүүдийг томилох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох; (x) энэхүү Гэрээний 3.2, 9.2, 9.3, 10.1-д заасныг баримтлан Хувь нийлүүлэгчид Компанийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу Компанийн хувьцаа, эсхүл бусад үнэт цаасыг тэргүүн ээлжинд худалдан авах эрх эдлэх эсэх; (xi) Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан тайланг хэлэлцэж батлах; (xii) Компанийн тухай хуулийн 11 дүгээр бүлэгт заасан их хэмжээний хэлцлийг батлах; (xiii) Компанийн тухай хуулийн дагуу Компани өөрийн хувьцаагаа худалдан авахыг зөвшөөрөх; (xiv) Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн гишүүдэд олгох цалин хөлс, урамшууллын хэмжээг тогтоох; | <p>version of the Charter;</p> <ul style="list-style-type: none"> (ii) reorganization of the Company by consolidation, merger, division or transformation; (iii) an exchange of the Company's debts for Shares; (iv) reorganization of the Company by transformation; (v) liquidation of the Company and the appointment of a liquidation commission; (vi) a split of or consolidation of the Company's Shares; (vii) subject to clause 5 of this Agreement, the completion of any conflict of interest transaction specified in Chapter 12 of the Company Law; (viii) election of members of the Board of Directors and termination of their powers prior to the expiration of their terms; (ix) election of members of the Supervisory Board and termination of their powers prior to the expiration of their terms; (x) subject to clauses 3.2, 9.2, 9.3 and 10.1, whether the Shareholders shall have the pre-emptive rights to acquire the Company's shares or other securities as provided for in Article 39 of the Company Law; (xi) consideration and approval of reports prepared by the Board of Directors with respect to the Company's annual operations and financial statements; (xii) approval of any major transactions specified in Chapter 11 of the Company Law; (xiii) approval of any acquisition of its shares by the Company pursuant to the Company Law; (xiv) approving the amount of salaries and bonuses to be given to the members of the Board of Directors unless otherwise provided in the Company's Charter; (xv) other matters submitted to the meeting by the Board of |
|--|--|

| | |
|--|---|
| <p>(xv) Хувь нийлүүлэгчдийн хуралд ТУЗ-өөс оруулсан бусад асуудал;</p> <p>(xvi) Компанийн тухай хууль, эсхүл Компанийн дүрэмд заасны дагуу хувь нийлүүлэгчдийн хурлаар батлуулах шаардлагатай бусад асуудал.</p> <p>(б) Энэхүү Гэрээний 4.10(a)(i)-аас 4.10(a)(vii) (4.10(a)(vii)-г оруулж тооцно)-д заасан Хувь нийлүүлэгчдийн хурлаар шийдвэрлэх шаардлагатай асуудлыг тухайн хуралд оролцож байгаа нийт саналын эрхийн Дийлэнх олонхийг эзэмшиж буй Хувь нийлүүлэгчид, эсхүл Хувь нийлүүлэгчийн төлөөлөгчдийн дэмжсэн саналаар шийдвэрлэнэ. Энэхүү Гэрээний 4.10(a)-д заасан бусад бүх асуудлыг тухайн хуралд оролцож байгаа нийт саналын эрхийн олонхийг эзэмшиж буй Хувь нийлүүлэгчид, эсхүл Хувь нийлүүлэгчийн төлөөлөгчдийн дэмжсэн саналаар шийдвэрлэнэ;</p> <p>(в) Хувь нийлүүлэгчдийн хурлыг хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрт Хувь нийлүүлэгчдийн товлосон хурлын зарыг Хувь нийлүүлэгчдэд доод тал нь 2 (хоёр) долоо хоногийн өмнө хүргүүлсэн байх талаар тусгана;</p> <p>(г) ТӨК-аас 1 (нэг) төлөөлөгч, Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс 1 (нэг) төлөөлөгч хүрэлцэн ирснээр Хувь нийлүүлэгчдийн хурлын ирц бүрдэнэ. Хувь нийлүүлэгчдийн хурал эхлэхэд ирц бүрдээгүй бол Хувь нийлүүлэгчдийн аливаа хурлаар тухайн хурлыг хойшлуулахаас өөр аливаа асуудлыг шийдвэрлэхгүй;</p> <p>(д) Хэрэв хувь нийлүүлэгчдийн хурлын ирц зар мэдээнд заасан эхлэх цагаас хойш 30 (гуч)-н минутын дотор бүрдээгүй бол тухайн хурал дараа долоо хоногийн мөн өдөр, цаг, газарт хуралдахаар хойшлогдоно. Хойшилсон хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж болохгүй. Хэрэв хойшилсон хурлын ирц товлосон хугацаанаас хойш 30 (гуч)-н минутын дотор бүрдээгүй бол тухайн хурал дараа долоо хоногийн мөн өдөр, цаг, газарт хуралдахаар дахин хойшлогдоно. Дахин хойшилсон хурлын хэлэлцэх асуудалд өөрчлөлт оруулж болохгүй. Хоёр дахь удаагаа хойшилсон хурлын ирц Компанийн Хувьцааны 20 (хорь)-иос доошгүй хувийг эзэмшдэг, саналын эрхтэй Хувь нийлүүлэгч, эсхүл Хувь нийлүүлэгчдийн төлөөлөгч буюу төлөөлөгчид хүрэлцэн ирснээр бүрдэнэ.</p> | <p>Directors; and</p> <p>(xvi) other matters required to be submitted to a shareholder meeting for approval as provided in the Company Law or in the Company’s Charter.</p> <p>(b) Matters that require shareholder approval under clause 4.10(a)(i) to clause 4.10(a)(vii) (inclusive) will be made by the affirmative vote of the representatives of a Shareholder or Shareholders holding an Overwhelming Majority of the total voting rights present at a meeting of Shareholders. All other matters under clause 4.10(a) will be made by the affirmative vote of the representatives of a Shareholder or Shareholders holding a majority of the total voting rights present at a meeting of Shareholders.</p> <p>(c) A resolution by the Board of Directors to convene a Shareholders’ meeting must include that the Shareholders be given at least two (2) weeks prior notice of the Shareholders’ meeting.</p> <p>(d) A quorum for a meeting of Shareholders is constituted by the presence of one representative of SHC, and one representative of the Ivanhoe Shareholders. No business may be transacted at any meeting of Shareholders unless a quorum is present at the commencement of the meeting, except for the adjournment of the meeting.</p> <p>(e) If there is not a quorum at a meeting of Shareholders within 30 minutes after the time specified in the notice of meeting, the meeting will stand adjourned to the same day in the following week at the same time and place. No changes may be made in the agenda for the adjourned meeting. If there is not a quorum at the adjourned meeting within 30 minutes after the time for that meeting, the meeting will stand adjourned again to the same day in the following week at the same time and place. No changes may be made in the agenda for the adjourned meeting. There shall be a quorum at the second adjourned meeting if a representative or representatives of a Shareholder or Shareholders entitled to vote, and holding at least twenty percent (20%) of the Shares of the Company, are present.</p> |
|--|---|

| | |
|---|---|
| <p>4.11 Хувь нийлүүлэгчид санал өгөх</p> <p>Хувь нийлүүлэгч бүр өөрийн эзэмшиж буй Хувьцааны тоотой тэнцүү саналын эрхтэй байна.</p> <p>4.12 Дотоодоос ханган нийлүүлэх үүрэг</p> <p>Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн үйлчилгээ болон Монгол Улсад байгаа тоног төхөөрөмж, түүхий эд, хангамжийн материал, сэлбэг хэрэгслийн үнэ өртөг, нийлүүлэх хугацаа, тоо хэмжээ, чанарын хувьд өрсөлдөхүйц байх тохиолдолд Компани тэдгээрийг тэргүүн ээлжинд худалдан авна. Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж буй бизнесийн байгууллагуудыг тэргүүн ээлжинд авч үзэхийн зэрэгцээ Оюу толгой төсөлд шаардагдах ачаа болон тээвэрлэлтийн үйлчилгээг Монгол талын нийлүүлэгчдээр тэргүүн ээлжинд гүйцэтгүүлнэ.</p> | <p>4.11 Voting by Shareholders</p> <p>Each Shareholder is entitled to that number of votes which is equivalent to the number of Shares held by it.</p> <p>4.12 Domestic procurement obligation</p> <p>The Company shall, on a priority basis, purchase and utilize services supplied by Mongolian citizens and/or legal entities, and equipment, raw materials, materials and spare parts manufactured in Mongolia, with preference to businesses operating in the Umnugovi Aimag, to the extent such services and materials are available on a competitive time, cost, quantity and quality basis, and shall give preference to Mongolian suppliers of freight and transportation services required for the OT Project.</p> |
| <p>5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл</p> <hr/> <p>5.1 Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлгийг хэрэглэх</p> <p>Энэхүү Гэрээний 5.2-т зааснаас бусад тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах Компанийн тухай Монгол Улсын хуулийн заалтууд, түүний дотор уг хуулийн 12 дугаар бүлгийг Компанийн үйл ажиллагаанд мөрдөнө.</p> <p>5.2 Хамааралтай хэлцэл</p> <p>Компанийн тухай Монгол Улсын хуулийн 86.4-т заасны дагуу нэг талаас Компани болон нөгөө талаас аль нэг Хувь нийлүүлэгч, эсхүл түүний Хамаарал бүхий компанийн хооронд хийгдэх аливаа хэлцэлд Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлгийн заалтыг хэрэглэхгүй гэж Компанийн дүрэмд тусгана. Хамааралтай хэлцлийн хувьд дараахь заалтуудыг баримтална:</p> | <p>5. Conflict of interest transactions</p> <hr/> <p>5.1 Application of Chapter 12 of the Company Law</p> <p>Except in the circumstances described in clause 5.2, the provisions of the Company Law of Mongolia relating to conflict of interest transactions including Chapter 12 of the Company Law shall apply with respect to the Company.</p> <p>5.2 Relevant Transactions</p> <p>In accordance with Article 86.4 of the Company Law of Mongolia, the Company’s Charter shall state that Chapter 12 of the Company Law shall not apply to any transaction between the Company (on the one hand) and any Shareholder or Related Corporation of any Shareholder (on the other hand). In respect of Relevant Transactions, the following provisions apply:</p> |

| | |
|--|---|
| <p>(a) Хувь нийлүүлэгчдээс урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр Компани нь Хамааралтай хэлцэл хийж болох бөгөөд аливаа Хамааралтай хэлцэл нь:</p> <p>(i) зах зээлийн өрсөлдөхүйц үнээр хийгдсэн байх ёстой;</p> <p>(ii) харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд тохиролцоо арилжааны нөхцөлтэй дүйцэхүйц нөхцөлөөр хийгдсэн байх ёстой;</p> <p>(iii) Хувь нийлүүлэгчдэд шуурхай мэдээлэгдсэн байх ёстой.</p> <p>(б) ТУЗ-ийн гишүүн бүр аливаа Хамааралтай хэлцлийн талаар саналаа өгнө. Хэрэв аль нэг Хувь нийлүүлэгч уг хэлцлийг энэхүү Гэрээний 5.2(a)-д заасан шаардлагыг хангаагүй гэж үзвэл Компани болон бусад Хувь нийлүүлэгчдэд мэдэгдэл өгч болно. Энэ тохиолдолд дараахь заалтуудыг баримтлана:</p> <p>(i) тухайн Хувь нийлүүлэгч мэдэгдлээ Хамааралтай хэлцлийн талаар мэдээлэл авсан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор хүргүүлэх бөгөөд уг мэдэгдэлдээ тухайн хэлцэл ямар үндэслэл, шалтгаанаар энэхүү Гэрээний 5.2(a)-д заасан шалгуурыг хангахгүй байна гэж үзэж байгаагаа дурдсан байна;</p> <p>(ii) тухайн Хамааралтай хэлцлийг ТУЗ-ийн дараагийн хурлаар хэлэлцэнэ;</p> <p>(iii) Хэрэв Хувь нийлүүлэгч ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн Хамааралтай хэлцлийн хэлэлцүүлэгт сэтгэл ханамжгүй байгаа бол тэрээр энэ тухай мэдэгдэлээ уг хурал болсноос хойш 7 (долоо) хоногийн дотор бусад Хувь нийлүүлэгч болон ТУЗ-д өгнө. Үүний дараа Хувь нийлүүлэгчид тухайн Хамааралтай хэлцэл энэхүү Гэрээний 5.2(a)-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар үнэлгээ хийлгэхээр зохих шалгуурыг хангасан хараат бус шинжээчийг хамтран томилно;</p> | <p>(a) The Company is permitted, without the prior approval of the Shareholders, to enter into Relevant Transactions, provided that each Relevant Transaction must be:</p> <p>(i) at a competitive market price;</p> <p>(ii) on commercial terms comparable to what would be agreed between unrelated parties; and</p> <p>(iii) promptly disclosed to the Shareholders.</p> <p>(b) Each Director shall vote on any Relevant Transaction. If a Shareholder considers that a Relevant Transaction does not meet the criteria of clause 5.2(a), then it may give notice to the Company and the other Shareholders, and the following provisions shall apply:</p> <p>(i) The notice shall be given within 30 days of the Relevant Transaction being disclosed to the Shareholder and shall include reason(s) why the Shareholder believes the Relevant Transaction does not meet the criteria of clause 5.2(a).</p> <p>(ii) The Relevant Transaction shall be discussed at the next meeting of the Board of Directors.</p> <p>(iii) If a Shareholder is not satisfied with the discussion on the Relevant Transaction at that meeting of the Board of Directors, it shall give notice to the other Shareholders and the Board of Directors within 7 days after that meeting, and the Shareholders shall then jointly appoint a suitably qualified independent expert to assess whether or not the Relevant Transaction meets the criteria in clause 5.2(a).</p> |
|--|---|

| | |
|---|---|
| <p>(iv) Хэрэв Хувь нийлүүлэгчид энэхүү Гэрээний 5.2(б)(iii)-д заасан мэдэгдэл өгснөөс хойш 15 (арван тав)-н хоногийн дотор хараат бус шинжээчийг томилох талаар тохиролцож чадаагүй бол тухайн шинжээчийг Хувь нийлүүлэгчдийн харилцан зөвшөөрсөн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий аудитын болон нягтлан бодох бүртгэлийн компани сонгоно;</p> <p>(v) Хараат бус шинжээч Хамааралтай хэлцлийг энэхүү Гэрээний 5.2(а)-д заасан шалгуурыг хангахгүй байна гэж тогтоох тохиолдолд тухайн Хамааралтай хэлцлийг хүчингүйд тооцохгүй. Гэхдээ тухайн Хамааралтай хэлцлийн нэг тал болох Хувь нийлүүлэгч (эсхүл түүний Хамаарал бүхий компани нь Хамааралтай хэлцлийн нэг тал бол) энэхүү Гэрээний 5.2(а)-д заасан шалгуурыг хангаагүйн улмаас Компанид учирсан аливаа хохирлыг хариуцна;</p> <p>(vi) Хараат бус шинжээчийн гаргасан дүгнэлтээс үл хамааран уг шинжээчийн бүх зардлыг Компани хариуцна.</p> <p>(в) Хувь нийлүүлэгчийн хүсэлтээр Компани болон бусад Хувь нийлүүлэгч нь энэхүү Гэрээний 5.2(а)-д заасан шалгуурыг Хамааралтай хэлцэл хангаж байгааг харуулах зохих түвшний шаардлагатай мэдээллээр тухайн Хувь нийлүүлэгчийг хангана.</p> | <p>(iv) If the Shareholders cannot agree on an independent expert within 15 days of the notice under clause 5.2(b)(iii), the independent expert shall be chosen by an internationally recognised and reputable audit and accounting firm jointly agreed upon by the Shareholders.</p> <p>(v) If the independent expert finds that the Relevant Transaction does not meet the criteria in clause 5.2(a), that Relevant Transaction shall not be void, however, the Shareholder that is a party to the Relevant Transaction (or whose Related Corporation is a party to the Relevant Transaction) shall be liable for any loss caused to the Company as a result of the departure from the criteria in clause 5.2(a).</p> <p>(vi) Notwithstanding the finding of the independent expert, the Company shall bear all the costs of the independent expert.</p> <p>(c) At the request of a Shareholder, the Company and the other Shareholders will provide that Shareholder with information reasonably necessary to satisfy that the Relevant Transaction meets the criteria in clause 5.2(a).</p> |
| <p>6. Гүйцэтгэх удирдлага болон Менежментийн баг</p> | <p>6. Executive body and Management Team</p> |
| <p>6.1 Гүйцэтгэх удирдлага</p> <p>Компанийн гүйцэтгэх удирдлага нь Компанийн удирдах албан тушаалтнуудаас бүрдэх бөгөөд Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцна.</p> | <p>6.1 Executive body</p> <p>The executive body of the Company shall comprise the Company’s senior management and shall be responsible for the Company’s day-to-day activities.</p> |

| | |
|--|---|
| <p>6.2 Менежментийн баг</p> <p>(a) ТУЗ нь АйВиЭн, эсхүл ОТН буюу тэдгээрийн нэг буюу түүнээс дээш Хамаарал бүхий компанийг дангаар нь, эсхүл бүлэг болгон хамтад нь (цаашид “Менежментийн баг” гэх) авч ажиллуулна. Менежментийн баг нь энэхүү Гэрээний 6.1-д заасан гүйцэтгэх удирдлагад Компанийн үйл ажиллагаа, түүний дотор Үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад нь туслалцаа, үйлчилгээ үзүүлнэ;</p> <p>(б) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь Менежментийн багийг өөрчлөх саналыг тухай бүр гаргаж болох бөгөөд ТУЗ нь санал болгосон Менежментийн багийг өөрчилж, томилох асуудлыг шийдвэрлэнэ;</p> <p>(в) Гүйцэтгэх удирдлага Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад Менежментийн багаас үзүүлэх үйлчилгээ, туслалцаа нь инженеринг, үйл ажиллагаа, төлөвлөлт болон үнэлгээ, байгаль орчин, маркетинг, ханган нийлүүлэлт, хууль зүй, худалдаа, төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээ, түүнчлэн Үндсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай гэж үзсэн бусад бүхий л үйлчилгээнээс бүрдэж болно.</p> | <p>6.2 Management Team</p> <p>(a) The Board of Directors shall engage IVN or OTN, or one or more Related Corporations of IVN or OTN, to act individually, or collectively as a group (the <i>Management Team</i>). The Management Team shall provide services and support to the executive body described in clause 6.1 in respect to the Company’s operations and activities, including the Core Operations.</p> <p>(b) The Ivanhoe Shareholders may, from time to time, nominate a replacement Management Team and the Board of Directors shall resolve to appoint the nominated replacement Management Team.</p> <p>(c) The services and support provided by the Management Team to enable the executive body to fulfil the Company’s day-to-day activities may include engineering, operational, planning and evaluation, environmental, marketing, procurement, legal, commercial, treasury and financial services, and any other services that are reasonably considered to be necessary for the efficient conduct of Core Operations.</p> |
| <p>6.3 Менежментийн багийн чиг үүрэг</p> <p>(a) Менежментийн баг нь энэхүү Гэрээний 6.1-д заасан гүйцэтгэх удирдлагын зүгээс Компанийн үйл ажиллагаа, түүний дотор Үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардлагатай тулалцаа, үйлчилгээ үзүүлэх бүхий л эрх, эрх мэдэлтэй байна;</p> <p>(б) ТУЗ нь шаардлагатай, эсхүл зүйтэй гэж үзвэл Менежментийн багийн үйл ажиллагаанд хяналт тавих бөгөөд түүнтэй холбоотой ажиллана. Менежментийн баг Компанийн үйл ажиллагааны талаар ТУЗ-д улирал тутам бичгээр тайлагнана. Менежментийн багийг хариуцан ажиллаж буй этгээд (эсхүл түүний эзгүйд төлөөлөгч нь) 4.6(a)-д заасан ТУЗ-ийн улирал тутмын хуралд оролцоно. Тайланг тухайн улирал дууссанаас хойш 30 (гуч)</p> | <p>6.3 Management Team functions</p> <p>(a) The Management Team shall have all rights and authorities required to provide services and support to the executive body described in clause 6.1 in respect to the Company’s operations and activities, including the Core Operations.</p> <p>(b) The Board of Directors shall monitor the activities of and liaise with the Management Team as necessary or appropriate. The Management Team shall report on a quarterly basis in writing to the Board of Directors in relation to the Company’s operations and activities. The individual responsible for the Management Team (or in his or her absence, their representative) will attend each quarterly meeting of the Board of Directors under clause 4.6(a). Each report shall be given to the Board of Directors within 30 days after the end of a quarter.</p> |

хоногийн дотор ТУЗ-д хүргүүлнэ.

6.4 Менежментийн үйлчилгээний төлбөр

- (a) Компани нь Менежментийн багт Менежментийн үйлчилгээний төлбөрийг төлнө;
- (б) Менежментийн үйлчилгээний төлбөрийг улирал бүрээр тооцож, тухайн улирлын эцсийн өдрөөс хойш 10 (арав)-н Ажлын өдрийн дотор төлнө;
- (в) Менежментийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ нь:
 - (i) Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр хүртэлх хугацаанд тухайн хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 3 (гурав)-н хувь;
 - (ii) Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойшхи хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 6 (зургаа)-н хувь байна.
- (г) Хувь нийлүүлэгчид нь тухайн Санхүүгийн жилийн аудит хийлгэсэн санхүүгийн тайлан гармагц аль болох хурдан хугацаанд уг тайланд тусгасан Үндсэн хөрөнгийн болон Үйл ажиллагааны зардлыг тухайн Санхүүгийн жилийн Менежментийн үйлчилгээний төлбөрийг тооцохдоо ашигласан Үндсэн хөрөнгийн болон Үйл ажиллагааны зардалтай тулгана. Аудитыг ТУЗ-өөс томилсон, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүнд бүхий аудитын болон нягтлан бодох бүртгэлийн компаниар хийлгэнэ. Хэрэв зөрүү гарвал Компани, эсхүл Менежментийн баг (тухайн тохиолдлоос хамаарч төлөх ёстой тал) нь тухайн Санхүүгийн жилд төлсөн Менежментийн үйлчилгээний төлбөрийн зөрүүг арилгах зорилгоор холбогдох төлбөрийг нөгөө талдаа шуурхай төлнө;
- (д) Менежментийн баг нь өөрийн үйлчилгээний тодорхой хэсгийг болон дэмжих чиг үүргээ АйВиЭн, эсхүл ОТН-ийн Хамаарал

6.4 Management Services Payment

- (a) The Company must pay to the Management Team the Management Services Payment.
- (b) The Management Services Payment will be calculated and payable quarterly in arrears and within 10 Working Days of the end of that quarter.
- (c) The amount of the Management Services Payment will be:
 - (i) 3% of all Capital Costs and Operating Costs incurred in the period from the Effective Date up to the Commencement of Production; and
 - (ii) 6% of all Capital Costs and Operating Costs incurred after the Commencement of Production.
- (d) As soon as practicable after the audited financial statements for the Company for a Financial Year are available, which audit shall be conducted by an internationally recognised and reputable audit and accounting firm appointed by the Board of Directors, the Shareholders will reconcile the Capital Costs and Operating Costs shown in those statements against the Capital Costs and Operating Costs used in the calculation of the Management Services Payment in respect of that Financial Year. If there is a discrepancy, then the Company or the Management Team (as the case may be) shall promptly make a payment to the other in order to adjust the Management Services Payment that has been paid in respect of that Financial Year.
- (e) The Management Team may sub-contract or assign part of its service and support functions to a Related Corporation of IVN or OTN. If the Management Team does so, then the Company shall directly pay to that Related Corporation of IVN or OTN (as applicable) the part

| | |
|--|--|
| <p>бүхий компанид шилжүүлэх, эсхүл тэдгээрээр туслан гүйцэтгүүлж болно. Хэрэв Менежментийн баг ингэж шийдвэрлэвэл Компани нь тухайн чиг үүрэгт (Менежментийн багийн тодорхойлсноор) хамаарах Менежментийн үйлчилгээний төлбөрийн холбогдох хэсгийг АйВиЭн, эсхүл ОТН-ийн Хамаарал бүхий компанид шууд төлнө. Түүнчлэн Менежментийн баг нь Менежментийн үйлчилгээний төлбөрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Айвенхоу групп, эсхүл Рио Тинто группын аль нэг гишүүнд шууд төлөхийг Компанид бичгээр даалгаж болно;</p> <p>(e) ТУЗ нь Санхүүгийн жил бүрийн сүүлчийн улиралд тухайн Санхүүгийн жил дэх Менежментийн багийн үүргийн гүйцэтгэлийг авч хэлэлцэнэ;</p> <p>(ё) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид хамтдаа, эсхүл тэдгээрийн аль нэг нь Менежментийн багийг төлөөлж болон түүний нэрийн өмнөөс энэхүү Гэрээг хэрэгжүүлж болно (тухайлбал энэхүү Гэрээний 22-т заасан маргааны талаар мэдэгдэл гаргах замаар).</p> | <p>of the Management Services Payment relating to such functions (as may be specified by the Management Team). The Management Team may also direct the Company in writing to directly pay to any member of the Ivanhoe Group or the Rio Tinto Group the whole or any part of the Management Services Payment.</p> <p>(f) During the final calendar quarter of each Financial Year, the Board of Directors will conduct an annual review of the Management Team’s performance of its functions during that Financial Year.</p> <p>(g) Either or both of the Ivanhoe Shareholders may enforce this Agreement for and on behalf of the Management Team (including by the issue of a notice of dispute under clause 22).</p> |
| <p>7. Төсөв болон санхүүгийн мэдээлэл</p> <p>7.1 Жилийн төлөвлөгөө болон төсөв</p> <p>(a) Компани (эсхүл Менежментийн баг) нь Гүйцэтгэлийн өдрөөс хойш 10 (арав)-н Ажлын өдрийн дотор тухайн Санхүүгийн жилийн үлдэж байгаа хугацааны Компанийн үйл ажиллагааны анхны хөтөлбөр, төсвийг ТУЗ-д хүргүүлнэ. ТУЗ нь тухайн хөтөлбөр, төсвийг хэлэлцэж шийдвэрлэх зорилгоор хуралдана;</p> <p>(б) Үүнээс хойш Компани (эсхүл Менежментийн баг) нь Санхүүгийн жил эхлэхээс өмнө тухайн Санхүүгийн жилд хэрэгжүүлэх Компанийн үйл ажиллагааны хөтөлбөр болон төсвийн төслийг жил бүр боловсруулж ТУЗ-д батлуулахаар хүргүүлнэ;</p> <p>(в) ТУЗ тухайн Санхүүгийн жил эхлэхээс доод тал нь 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө үйл ажиллагааны хөтөлбөр бүр болон</p> | <p>7. Budgets & financial information</p> <p>7.1 Annual plans & budgets</p> <p>(a) Within 10 Working Days after the Completion Date, the Company (or the Management Team) shall submit to the Board of Directors the first operating program and budget for the Company in respect of the remainder of the Financial Year and the Board of Directors shall meet in order to consider and vote on that program and budget.</p> <p>(b) Before the commencement of each Financial Year thereafter, the Company (or the Management Team) must prepare and submit to the Board of Directors, for approval, a draft operating program and budget for the Company for that Financial Year.</p> <p>(c) The Board of Directors must consider and vote on each program and budget at least 30 days before the commencement of the Financial Year. Approval of a program and budget constitutes authority for the</p> |

| | |
|---|---|
| <p>төсвийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хөтөлбөр болон төсвийг баталснаар Компани болон Менежментийн баг нь тухайн хөтөлбөр болон төсвийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч, зөвшөөрөгдсөн бүх зарлагыг гаргах эрхтэй болно;</p> <p>(г) Шаардлагатай тохиолдолд Компани (эсхүл Менежментийн баг) нь шинэчлэн найруулсан, эсхүл нэмэлт оруулсан хөтөлбөр болон төсвийг боловсруулж ТУЗ-д батлуулахаар хүргүүлж болно.</p> <p>7.2 Санхүүгийн мэдээлэл</p> <p>Компани нь ТУЗ-ийн гишүүн болон Хувь нийлүүлэгч бүрийг дараахь мэдээллээр хангана:</p> <p>(а) хуанлийн сар бүр дуусмагц аудит хийлгээгүй менежментийн тайлан;</p> <p>(б) Санхүүгийн жил бүр дуусмагц аудит хийлгэсэн Компанийн санхүүгийн тайлангийн хувь;</p> <p>(в) Хувь нийлүүлэгчид, эсхүл ТУЗ-ийн гишүүн тухай бүр үндэслэлтэйгээр авахыг шаардсан аливаа бусад мэдээлэл.</p> <p>7.3 Менежментийн тайлан</p> <p>Компани нь Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим (НББНХЗЗ), эсхүл Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС) болон Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандартад нийцүүлэн өөрийн менежментийн тайланг хөтөлнө.</p> | <p>Company and Management Team to undertake all relevant action and incur all approved expenditure for that program and budget.</p> <p>(d) The Company (or the Management Team) may, if circumstances require it, prepare a revised or supplementary program and budget and submit it to the Board of Directors for approval.</p> <p>7.2 Financial information</p> <p>The Company must provide to each Director and Shareholder:</p> <p>(a) after the end of each calendar month, unaudited management accounts;</p> <p>(b) after the end of each Financial Year, copies of the audited financial statements of the Company; and</p> <p>(c) any other information the Shareholders or a Director may at any time reasonably require.</p> <p>7.3 Management accounts</p> <p>The Company shall maintain its management accounts in conformity with GAAP or IFRS, and applicable Mongolian accounting standards.</p> |
| <p>8. Компанийн санхүүжилт</p> <p>8.1 Шаардсан мөнгөн хөрөнгө</p> <p>Компани (эсхүл түүний нэрийн өмнөөс Менежментийн баг) нь ТУЗ-ийн баталсан хөтөлбөр болон төсвийн хүрээнд Компанид шаардагдаж буй</p> | <p>8. Financing of Company</p> <p>8.1 Called Sums</p> <p>The Company (or on its behalf, the Management Team) may by notice in writing request the Shareholders to contribute funds in accordance with their</p> |

| | |
|--|---|
| <p>мөнгөн хөрөнгийн хэрэгцээг хангах зорилгоор Хувь нийлүүлэгчдэд өөрийн Эзэмшлийн хувь хэмжээндээ тэнцүүлэн хөрөнгө (цаашид тус бүрийг “Шаардсан мөнгөн хөрөнгө” гэх) оруулах хүсэлтийг бичгээр тавьж болно. Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид хүсэлт гаргасан тохиолдолд Шаардсан мөнгөн хөрөнгийн мэдэгдлийг Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдийн зөвшөөрсөн хувь хэмжээгээр, бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн төлүүлэхээр нэг, эсхүл түүнээс дээш Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид хүргүүлнэ (жишээлбэл ОТН болон АйВиЭн-ээс төлөх нийт Шаардсан мөнгөн хөрөнгийг нэгтгэн төлөх тухай мэдэгдлийг ОТН-д өгсөн бол АйВиЭн-д Шаардах мөнгөн хөрөнгийн мэдэгдэл өгөхгүй).</p> <p>8.2 Шаардсан мөнгөн хөрөнгийн санхүүжилт</p> <p>Талууд Шаардсан мөнгөн хөрөнгийг ТУЗ-өөс тухай бүрт тодорхойлсон арга хэлбэр (эсхүл хослуулсан арга хэлбэр)-ээр санхүүжүүлэхийг эрмэлзэнэ. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> (a) энгийн хувьцааны хэлбэрээр (Хувьцаа нэмж гаргах замаар); (б) давуу эрхтэй хувьцааны хэлбэрээр (давуу эрхийн хувьцаа (Санхүүжүүлэх хувьцааг оролцуулан) нэмж гаргах замаар); (в) өрийн хэлбэрээр (Хувь нийлүүлэгчийн өрийн хэлбэрээр). <p>Санхүүжилтийн хугацаанд энэхүү Гэрээний 10, 11 болон 12 дугаар зүйлүүд үйлчилнэ.</p> <p>8.3 Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх</p> <ul style="list-style-type: none"> (a) Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх Айвенхоугийн Хувь нийлүүлэгчийн үүргийг АйВиЭн-ийн Санхүүжүүлэгч, эсхүл Айвенхоугийн өөр Хувь нийлүүлэгч, эсхүл Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн гүйцэтгэж болохыг Талууд харилцан зөвшөөрөв (ОТН нь Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх өөрийн болон АйВиЭн-ийн бүх үүргийг гүйцэтгэж болох бөгөөд энэ тохиолдолд АйВиЭн Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй). | <p>Percentage Interests to meet the projected cash requirements of the Company under the programs and budgets approved by the Board of Directors (each a <i>Called Sum</i>). At the Ivanhoe Shareholders request, Called Sum notices will be issued to one or more Ivanhoe Shareholders for the whole or any part of their combined Called Sums in the proportions directed by the Ivanhoe Shareholders (for example, to OTN for the whole amount of the OTN and IVN combined Called Sums, in which case IVN would not be issued a Called Sum notice).</p> <p>8.2 Financing of Called Sums</p> <p>The Parties intend that Called Sums shall be discharged by the methods (or by a combination of methods) determined by the Board of Directors from time to time, including:</p> <ul style="list-style-type: none"> (a) by way of common equity (via the issue of Shares); (b) by way of preferred equity (via the issue of preferred shares (including Funding Shares)); and (c) by debt (via Shareholder Debt), <p>and during the Funding Period clauses 10, 11 and 12 shall apply.</p> <p>8.3 Contributions to Called Sums</p> <ul style="list-style-type: none"> (a) The Parties agree that an Ivanhoe Shareholder’s obligations to contribute to Called Sums may be discharged in whole or in part by the IVN Provider or another Ivanhoe Shareholder or Ivanhoe Shareholders (for example, OTN may discharge the whole of IVN’s obligation and OTN’s obligation to contribute to a Called Sum, in which case IVN would not contribute its Called Sum). (b) All contributions of Called Sums must be in USD unless required otherwise by the Board of Directors. If the Board of Directors so resolves, then the Parties must make contributions in the currency or |
|--|---|

| | |
|--|--|
| <p>(б) ТУЗ өөрөөр шийдвэрлээгүй тохиолдолд Шаардсан мөнгөн хөрөнгийн бүх нийлүүлэлтийг ам.доллараар хийнэ. ТУЗ өөрөөр шийдвэрлэсэн тохиолдолд Талууд энэхүү Гэрээний 8.1-д заасны дагуу хүргүүлсэн Шаардсан мөнгөн хөрөнгийн мэдэгдэлд заасан нэг, эсхүл хэд хэдэн валютаар нийлүүлэлтийг хийнэ.</p> | <p>currencies specified in any notice of a Called Sum given under clause 8.1.</p> |
| <p>8.4 Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх хүсэлт гаргах хугацаа</p> <p>(a) Гүйцэтгэлийн өдөр болон түүнээс хойш энэхүү Гэрээний 8.1-д заасан мөнгөн хөрөнгө нийлүүлэх хүсэлтийг хуанлийн улирал тутам тавьж болох бөгөөд уг хүсэлтийг тухайн улирал эхлэхээс өмнө Хувь нийлүүлэгчдэд хүргүүлсэн байна.</p> <p>(б) Энэхүү Гэрээний 7.1(a)-д заасны дагуу баталсан хөтөлбөр болон төсвийн хувьд тухайн хөтөлбөр болон төсвийг баталсан даруйд мөнгөн хөрөнгө нийлүүлэх анхны хүсэлтийг гаргаж болно.</p> | <p>8.4 Periods covered by Called Sums</p> <p>(a) On and from the Completion Date, requests for contributions under clause 8.1 may be made for each calendar quarter and delivered to the Shareholders before the start of each calendar quarter.</p> <p>(b) The first request for contributions may be made in respect of the program and budget approved in accordance with clause 7.1(a) immediately after that program and budget is approved.</p> |
| <p>8.5 Шаардсан мөнгөн хөрөнгийн төлбөр хийх хугацаа</p> <p>Шаардсан мөнгөн хөрөнгийг энэхүү Гэрээний 8.1-д заасан хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 (гуч) хоногийн дотор Компанид төлнө.</p> | <p>8.5 When Called Sums are due</p> <p>A Called Sum will be due and payable to the Company within 30 days of receipt of the request under clause 8.1.</p> |
| <p>8.6 Энэхүү Гэрээний 8 дугаар зүйлийг хэрэглэх</p> <p>Компани нь энэхүү Гэрээний 4.10(a)(v), эсхүл Компанийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу Компанийг татан буулгах ажиллагаа эхэлснээс хойш Шаардсан мөнгөн хөрөнгө нийлүүлэх хүсэлт гаргахгүй.</p> | <p>8.6 Application of Clause 8</p> <p>The Company shall not issue Called Sums after the commencement of the liquidation of the Company pursuant to clause 4.10(a)(v) or Article 26.1 of the Company Law.</p> |
| <p>8.7 Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүү</p> <p>Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийн хүүг Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн тооцож эхэлнэ.</p> | <p>8.7 Interest on Existing Shareholder Loans</p> <p>Interest on the Existing Shareholder Loans shall accrue on and from the Effective Date.</p> |

| | |
|---|---|
| <p>9. Санхүүжилтийн зохицуулалт</p> | <p>9. Financing arrangements</p> |
| <p>9.1 Санхүүжилтийн хугацаанд нийлүүлэх хөрөнгө</p> <p>Санхүүжилтийн хугацаанд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь нийт Шаардсан мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр нийлүүлэхээр (энэхүү Гэрээний 10.1-д өөрөөр тусгайлан заагаагүй бол) болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь энэхүү Гэрээний 8.2-т заасан нийлүүлэлтийн аль нэг хэлбэр, эсхүл хэлбэрүүдийг тодорхойлохоор (Хөрөнгө оруулалтын гэрээнд заасан “зээл, хөрөнгө оруулалтын харилцаа”-ны шаардлагыг баримталж) Талууд харилцан тохиролцов.</p> <p>9.2 Санхүүжилтийн хугацааны дараахь үе</p> <p>(a) Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа Компани нь Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэх хүсэлтийг Хувь нийлүүлэгчдэд хэдийд ч тавьж болно. Хэрэв ТӨК Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь тухайн Шаардсан мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр нийлүүлж болно (гэхдээ ингэх үүрэг хүлээхгүй). Энэ тохиолдолд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь энэхүү Гэрээний 10, 11, 12-т заасан Санхүүжилтийн хэлбэрүүдийн аль хэлбэрийг хэрэглэхийг тодорхойлох бөгөөд үүнийг ТӨК болон Компани хүлээн зөвшөөрнө.</p> <p>(б) Санхүүжилтийн хугацааны дараа Компанийн Хувьцааг Хувь нийлүүлэгч бүрт дараахь байдлаар гаргаж олгоно:</p> <p>(i) Хувь нийлүүлэгч бүрийн Эзэмшлийн хувь хэмжээнд хамаарах Шаардсан мөнгөн хөрөнгийн хувь хэмжээгээр;</p> <p>(ii) ижил нөхцөл, болзолтойгоор.</p> <p>(в) Эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс ТӨК Шаардсан мөнгөн хөрөнгийг нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн тохиолдолд түүний Эзэмшлийн хувь хэмжээг бууруулж болохгүй. Санхүүжилтийн</p> | <p>9.1 Contributions during Funding Period</p> <p>The Parties agree that, during the Funding Period, the IVN Provider shall contribute the whole of all Called Sums (except as otherwise expressly provided for in clause 10.1), and the Ivanhoe Shareholders shall determine what method or methods of finance set out in clause 8.2 will apply in respect to those contributions (subject to the 'thin capitalisation' restrictions contained in the Investment Agreement).</p> <p>9.2 After Funding Period</p> <p>(a) At any time after the Funding Period, where the Company requests Shareholders to contribute to a Called Sum, if SHC elects not to contribute to a Called Sum, then the Ivanhoe Shareholders may elect (but are not obliged) to contribute the whole of the Called Sum, in which case the Ivanhoe Shareholders shall determine which of the financing methods described in clauses 10, 11 and 12 shall apply to any such contribution by the Ivanhoe Shareholders, and SHC and the Company must accept such contribution.</p> <p>(b) After the Funding Period, Shares in the Company must be issued to each Shareholder:</p> <p>(i) in proportion to the Called Sums which relate to each Shareholder's Percentage Interest; and</p> <p>(ii) on the same terms and conditions.</p> <p>(c) For the avoidance of doubt, if SHC elects not to contribute to a Called Sum, its Percentage Interest cannot be diluted and if, after the Funding Period, Shares are issued to the IVN Shareholders because the Ivanhoe Shareholders have elected to fund under or in a manner similar to clause 10 then Shares must also be issued in proportion to</p> |

| | |
|--|---|
| <p>хугацаа дууссаны дараа энэхүү Гэрээний 10-т заасан, эсхүл түүнтэй төстэй арга хэлбэрээр Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид санхүүжилт хийхээр шийдвэрлэж үүний улмаас АйВиЭн-ийн Хувь нийлүүлэгчдэд Хувьцаа олгох тохиолдолд ТӨК-д түүний Эзэмшлийн хувь хэмжээтэй тэнцэх Хувьцааг ижил нөхцөл, болзолтойгоор олгоно.</p> <p>(г) энэхүү Гэрээний 9.2-ын аливаа заалт нь ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг энэхүү Гэрээний 10.1(б)(ii)-ын дагуу санхүүжүүлэх ТӨК-ийн эрхийг хязгаарлахгүй бөгөөд Компани ийнхүү санхүүжүүлснийг нь хүлээн зөвшөөрнө.</p> <p>9.3 Санхүүжилтийн зохицуулалт</p> <p>Энэхүү Гэрээний 10, 11 дүгээр зүйлд заасан энгийн болон давуу эрхийн хувьцааны санхүүжилтийн зохицуулалтад үл нийцсэн тэргүүн ээлжинд худалдан авах аливаа эрхээ хэрэгжүүлэхгүй байхаар Хувь нийлүүлэгчид харилцан тохиролцов.</p> | <p>SHC's Percentage Interest on the same terms and conditions.</p> <p>(d) Nothing in this clause 9.2 restricts the rights of SHC to fund a SHC Called Sum in accordance with clause 10.1(b)(ii) and the Company must accept such contribution.</p> <p>9.3 Financing arrangements</p> <p>The Shareholders agree not to exercise any rights of pre-emption which are inconsistent with the common and preferred equity financing arrangements set out in clauses 10 and 11.</p> |
| <p>10. Энгийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийх</p> <p>10.1 Санхүүжилтийн хугацаанд ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг энгийн хувьцаа гаргах замаар санхүүжүүлэх</p> <p>(a) Санхүүжилтийн хугацаанд болон түүний дараа Хувь нийлүүлэгчид нь Шаардсан мөнгөн хөрөнгө бүрт өөрийн Эзэмшлийн хувь хэмжээний дагуу хөрөнгө нийлүүлнэ. Гэхдээ Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид энгийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийхээр тодорхойлсон тохиолдолд энэхүү Гэрээний 10.1(ж)-д заасныг баримтлан ТӨК нь Хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 3 (гурав)-н жилийн дотор Шаардсан мөнгөн хөрөнгө нийлүүлэх эрхээ эдлэхгүй. ТӨК нь Хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 3 (гурав)-н жил өнгөрсний дараа ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгө бүрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлж болно (гэхдээ ингэх үүрэг хүлээхгүй). ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хийхээр шийдвэрлэсэн</p> | <p>10. Common equity funding</p> <p>10.1 Carry of SHC Called Sums to be made by way of common equity during Funding Period</p> <p>(a) During and after the Funding Period, the Shareholders must contribute each Called Sum in accordance with their respective Percentage Interests. However, where the Ivanhoe Shareholders determine that funding will be made by way of common equity, subject to clause 10.1(h), SHC shall not be entitled to make any such contributions to SHC Called Sums on or before the date which is three (3) years after the Effective Date. After the date which is three (3) years after the Effective Date, SHC may (but is not obliged to) contribute to the whole or part of each SHC Called Sum. SHC shall give prior written notice to the Company and the Ivanhoe Shareholders of its election to so contribute the whole or part of an SHC Called Sum.</p> |

тохиолдолд энэ тухайгаа Компани болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдэд урьдчилан бичгээр мэдэгдэнэ.

(б) АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь:

(i) Гэрээ Хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 3 (гурав)-н жилийн дотор энэхүү Гэрээний 10-т заасны дагуу ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь ТӨК-ийн нэрийн өмнөөс Компанид төлнө;

(ii) Гэрээ Хүчин төгөлдөр болох өдрөөс хойш 3 (гурав)-н жилийн дараа ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийн ТӨК-ийн нийлүүлэхгүй гэж шийдвэрлэсэн хэсгийг энэхүү Гэрээний 10-т заасны дагуу ТӨК-ийн нэрийн өмнөөс Компанид төлнө.

(Дээр дурдсан (i), эсхүл (ii) дахь хэсгийн дагуу АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн санхүүжүүлсэн дүн бүрийг “**Санхүүжүүлсэн дүн**” гэнэ).

(в) Компанийн Хувьцааг Хувь нийлүүлэгч бүрт дараахь байдлаар гаргаж олгоно:

(i) Хувь нийлүүлэгч бүрийн Эзэмшлийн хувь хэмжээнд хамаарах Шаардсан мөнгөн хөрөнгийн хувь хэмжээгээр;

(ii) ижил нөхцөл, болзолтойгоор.

(г) Гүйцэтгэлийн өдрөөс эхлэн Компанийн санхүүжилтийн төлөвлөгөөг тодорхойлохдоо Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид ТӨК-тай зөвлөлдөнө. Үүнд боломжит санхүүжүүлэгчидэд зориулсан танилцуулах ажил, хөрөнгө босгох бусад үйл ажиллагаанд ТӨК-ийг оролцуулах зэрэг орно.

(д) Энэхүү Гэрээний 10-т заасан АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн ТӨК-аас шинээр Шаардсан мөнгөн хөрөнгийг (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн) ТӨК-ийн нэрийн өмнөөс санхүүжүүлэх үүрэг Санхүүжилтийн хугацаа дуусмагц дуусгавар болно.

(е) ТӨК нь гагцхүү энэхүү Гэрээний 15.6-д заасны дагуу 100 (зуу) хувь Төрийн өмчлөл болон хяналтад байх тохиолдолд энэхүү Гэрээний 10-т заасны дагуу Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг (бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн) ТӨК-ийн нэрийн өмнөөс Компанид төлөх үүрэг хүлээнэ.

(b) The IVN Provider must:

- (i) before the date three (3) years after the Effective Date, provide the whole of the SHC Called Sum to the Company on behalf of SHC, in accordance with this clause 10; and
- (ii) after the date three (3) years after the Effective Date, provide that part of the SHC Called Sums, to which SHC does not elect to contribute, to the Company on behalf of SHC, in accordance with this clause 10,

(and each such amount funded by the IVN Provider under paragraph (i) or (ii) above shall be a **Funded Amount**).

(c) Shares in the Company must be issued to each Shareholder:

- (i) in proportion to the Called Sums which relate to each Shareholder's Percentage Interest; and
- (ii) on the same terms and conditions.
- (iii)

(d) From the Completion Date, the Ivanhoe Shareholders will consult with SHC when determining financing plans for the Company. This will include involving SHC in presentations to potential financiers and other fundraising activities.

(e) The IVN Providers' obligation under this clause 10 to fund new SHC Called Sums (in whole or in part) on behalf of SHC ceases on the expiry of the Funding Period.

(f) The Ivanhoe Shareholders shall only be obliged to contribute SHC Called Sums (in whole or in part) to the Company on behalf of SHC under this clause 10 for so long as SHC remains wholly owned and Controlled by the State as contemplated by clause 15.6.

| | |
|--|---|
| <p>(ё) Хэрэв Санхүүжилтийн хугацаанд аливаа Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг нь энэхүү Гэрээний 10.1(б)-д заасны дагуу АйВиЭн-ийн Санхүүжүүлэгч санхүүжүүлж чадаагүй тохиолдолд ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээг бууруулж болохгүй бөгөөд энэхүү Гэрээний 10-т заасан, эсхүл түүнтэй төстэй арга хэлбэрээр Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид санхүүжилт хийхээр шийдвэрлэж үүний улмаас АйВиЭн-ийн Хувь нийлүүлэгчдэд Хувьцаа олгох тохиолдолд ТӨК-д түүний Эзэмшлийн хувь хэмжээтэй тэнцэх Хувьцааг ижил нөхцөл, болзолтойгоор олгоно.</p> <p>(ж) Хэрэв Санхүүжилтийн хугацаанд ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг ТӨК өөрөө нийлүүлэх боломжтой гэж үзвэл ТӨК Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдтэй зөвлөлдөнө. ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгийг санхүүжилтийн хугацаанд ТӨК өөрөө нийлүүлэх эрхтэй бөгөөд энэ нь дараахь бүх нөхцөл хангагдсан тохиолдолд хэрэгжинэ:</p> <ul style="list-style-type: none"> (i) Оюу Толгой Төслийг санхүүжүүлэх Айвенхоу группийн төлөвлөгөөнд сөргөөр нөлөөлөхгүй гэж Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид тодорхойлсон; (ii) ТӨК-ийн нийлүүлэх хөрөнгийн Санхүүжилтийн нөхцөл, болзлыг Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид зөвшөөрсөн; (iii) Компанийн хувьд ТӨК-ийн санхүүжилтийн нөхцөл, болзол нь АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нөхцөл, болзлоос илүү тааламжтай байвал. | <p>(g) If the IVN Provider fails to provide funding in accordance with clause 10.1(b) in respect of the whole or relevant part of a Called Sum during the Funding Period, then SHC’s Percentage Interest cannot be diluted, and if Shares are issued to the Ivanhoe Shareholders because the Ivanhoe Shareholders have elected to fund under or in a manner similar to this clause 10 then Shares must also be issued in proportion to SHC’s Percentage Interest on the same terms and conditions.</p> <p>(h) If, during the Funding Period, SHC considers it has the ability to make contributions to SHC Called Sums, SHC may consult the Ivanhoe Shareholders. SHC shall be entitled to make contributions to SHC Called Sums during the Funding Period if all of the following conditions are met:</p> <ul style="list-style-type: none"> (i) the Ivanhoe Shareholders have determined that such contributions will not negatively affect the Ivanhoe Group’s finance plan for the OT Project; and (ii) the Ivanhoe Shareholders’ agree to the terms and conditions of any financing arrangements SHC wishes to utilize to fund such contributions; and (iii) the terms and conditions of its contribution are more favourable to the Company than those of the IVN Providers. |
| <p>10.2 Санхүүжүүлсэн дүн</p> <p>(a) АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн Санхүүжүүлсэн дүн бүр нь түүнд энэхүү Гэрээний 10.3(a)-д заасан Санхүүжилтийн хүүгийн хувиар тооцож тогтоосон хүүгийн хамт ТӨК-аас АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид төлөх өр болно (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө). АйВиЭн-ийн санхүүжүүлэгч болон ТӨК нь ийм өрийн нөхцөлийг баримтжуулах зорилгоор зээлийн тусгайлсан гэрээг энэхүү Гэрээний нөхцөлд нийцүүлэн нэн даруй байгуулна.</p> | <p>10.2 Funded Amounts</p> <p>(a) Each Funded Amount provided by the IVN Provider, together with the interest prescribed in clause 10.3(a) at the Carry Rate, will constitute a debt payable by SHC to the IVN Provider (or to IVN or OTN on behalf of the IVN Provider, if the Ivanhoe Shareholders direct). A separate loan agreement shall be promptly entered into by the IVN Provider and SHC to record the terms of such debt in accordance with the terms of this Agreement.</p> |

| | |
|--|--|
| <p>(б) Энэхүү Гэрээний 15.6(в), 15.7(б)-д заасны дагуу Үлдэгдэл төлбөрийг бүхэлд нь төлж барагдуулахыг шаардсан, эсхүл 10.4(г)-д заасны дагуу Үлдэгдэл төлбөрийг бууруулснаас бусад тохиолдолд дээрхи өрийг зөвхөн ТӨК-д ногдох Ногдол ашгаас төлж барагдуулна.</p> <p>(в) Нийт энгийн хувьцааны нийлбэр нь Компанийн нийт хөрөнгийн (үүнд давуу эрхийн хувьцааг оролцуулаад) 60 (жар)-н хувиас хэтрэхгүй байна.</p> | <p>(b) This debt is repayable only out of SHC's Dividends, except where the Outstanding Balance is required to be repaid in full under clauses 15.6(c) and 15.7(b), or where the Outstanding Balance is reduced in accordance with clause 10.4(d).</p> <p>(c) The aggregate of all common equity shall not exceed 60% of the total capital (including preferred equity) of the Company.</p> |
| <p>10.3 Санхүүжилтийн хүүгийн хувь</p> | <p>10.3 Carry Rate</p> |
| <p>(a) Үлдэгдэл төлбөрт улирал тутам хүү (энэхүү Гэрээний 10.3(г)(ii)-д тодорхойлсны дагуу) тооцох бөгөөд тухайн хуанлийн улирал бүрийн Санхүүжилтийн хүүгийн хувиар тооцно.</p> <p>(б) Энэхүү Гэрээний 10.3(а)-д заасныг хангах зорилгоор өнгөрсөн өдрүүдийн бодит тоо болон 360 (гурван зуун жар)-н өдөр бүхий жилээр үндэслэн хүүг тооцно. Хуанлийн улирал нь Ажлын өдөр дуусаагүй тохиолдолд тухайн хуанлийн улирлыг дараагийн Ажлын өдөр хүртэл сунгаж тооцно.</p> <p>(в) Энэхүү Гэрээний 10.3(а)-д заасны дагуу хүү хуримтлагдах тухай бүрт Үлдэгдэл төлбөрийн нийлбэр дүнг АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийн өмнөх улирлын өөрчлөлтөд нийцүүлэн өөрчилнө.</p> <p>(г) Энэхүү Гэрээний зорилгоор:</p> <p>(i) Улирал тутмын “Санхүүжилтийн хүүгийн хувь” гэж нийлбэр дүнгээрээ жилийн 9,9 хувийн хүүтэй тэнцэх, улирал тутмын хүүгийн хувийг хэлнэ.</p> <p>(ii) “Үлдэгдэл төлбөр” гэж тухайн үед хуримтлагдсан дараахь дүнгүүдийн нийлбэрээс энэхүү Гэрээний 10.4-т заасны дагуу ТӨК-аас тухайн хугацааг хүртэл төлж барагдуулсан төлбөрийн нийт дүнг хассаныг хэлнэ:</p> | <p>(a) Interest shall be calculated on the Outstanding Balance (as defined in clause 10.3(d)(ii)) and accrued on a quarterly basis using, in respect of each quarter, the Carry Rate for that calendar quarter.</p> <p>(b) For the purposes of clause 10.3(a), interest will be computed on the basis of the actual number of days elapsed and a year of 360 days. If a calendar quarter ends on a day which is not a Working Day, that calendar quarter will be extended to the next Working Day.</p> <p>(c) Immediately after each accrual of interest pursuant to clause 10.3(a), the sum of the Outstanding Balance shall be adjusted for the variation in the US CPI over the preceding quarter.</p> <p>(d) For the purposes of this Agreement:</p> <p>(i) Carry Rate for a calendar quarter means the interest rate for a calendar quarter that results in an effective annual interest rate of 9.9%;</p> <p>(ii) Outstanding Balance means, at any point in time, the aggregate of:</p> <p>(A) all Funded Amounts that have been funded by the IVN Provider up to that point in time;</p> |

| | |
|--|--|
| <p>(A) АйВиЭн-ийн санхүүжүүлэгчээс тухайн хугацаа хүртэл төлсөн нийт Санхүүжилтийн дүн;</p> <p>(Б) энэхүү Гэрээний 10.3(а)-д зааснаар тухайн хугацаанаас өмнө хуримтлагдсан хүүгийн нийт дүн;</p> <p>(В) энэхүү Гэрээний 10.3(в)-д зааснаар тухайн хугацаа хүртэл Үлдэгдэл төлбөрийн дүнг АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийн өөрчлөлтөөр тохируулсан нийт дүн.</p> <p>(iii) “АНУ-ын Хэрэглээний Үнийн Индекс” гэж Америкийн Нэгдсэн Улсын Хөдөлмөрийн яамны харьяа Хөдөлмөрийн статистикийн товчооноос нийтэд хэвлэн гаргадаг CUUR0000SAO цувралын дугаар бүхий “Хотын нийт оршин суугч Хэрэглэгчдийн хэрэглээний үнийн индекс (CPI-U): зардал, өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний төрлөөр ангилан харуулсан АНУ-ын хотын дундаж” хэмээх индексийн 1 (нэг) дүгээр хүснэгтэд заасан улирал тутмын эцсийн жилийн индексийг, харин энэхүү индексийг хэвлэн гаргахгүй болсон тохиолдолд Хувь нийлүүлэгчид сайн санааны үүднээс хэлэлцээ хийх замаар харилцан зөвшөөрсөн шинэ, өөрчлөн найруулсан, эсхүл орлох индексийг, тийнхүү харилцан тохиролцож чадаагүй тохиолдолд Компанийн сонгосон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн аудит болон нягтлан бодох бүртгэлийн компанийн тодорхойлсон шинэ, өөрчлөн найруулсан, эсхүл орлох индексийг ойлгоно.</p> <p>(д) ТӨК болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь жил бүр Үлдэгдэл төлбөрийн тооцоог хамтран баталгаажуулна.</p> <p>10.4 Үлдэгдэл төлбөрийг буцаан төлөх</p> <p>(a) Компани нь энэхүү Гэрээний 14.2-т заасны дагуу бүх Үлдэгдэл</p> | <p>(B) all interest that has accrued under clause 10.3(a) prior to that point in time; and</p> <p>(C) all US CPI-related adjustments made to the sum of the Outstanding Balance pursuant to clause 10.3(c) up to that point in time,</p> <p>less all amounts repaid by SHC pursuant to clause 10.4 prior to that point in time; and</p> <p>(iii) US CPI means the Annual Index at the end of each Quarter contained in Table 1, Consumer Price Index for all Urban Consumers (CPI-U): US City Average, by Expenditure Category and Commodity and Service Group, series ID number CUUR0000SAO, published by the Bureau of Labor Statistics, which forms part of the United States Department of Labor and if the index ceases to be published, such new, revised or substitute index as is agreed between the Shareholders following reasonable and in good faith negotiations, and failing agreement such new, revised or substitute index as determined by an internationally recognised audit and accounting firm selected by the Company.</p> <p>(e) SHC and the Ivanhoe Shareholders shall together confirm the calculation of the Outstanding Balance on an annual basis.</p> <p>10.4 Repayment of Outstanding Balance</p> <p>(a) All monies payable to SHC as Dividends in respect of the Shares</p> |
|--|--|

| | |
|--|---|
| <p>төлбөрийг буцаан төлж дуусах хүртэл ТӨК-ийн эзэмшлийн Хувьцааны хувьд түүнд ногдох Ногдол ашиг болгон төлж буй бүх мөнгийг АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид төлнө (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө).</p> | <p>held by SHC must be paid by the Company to the IVN Provider (or to IVN or OTN on behalf of the IVN Provider, if the Ivanhoe Shareholders direct) until such time as all of the Outstanding Balance is repaid, in accordance with clause 14.2.</p> |
| <p>(б) ТӨК нь энэхүү Гэрээний 10.4(а)-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Гэрээний 14.2-г заасны дагуу Үлдэгдэл төлбөрийг эргүүлэн төлж дуусах хүртэл өөрт ногдох Ногдол ашгийг бүхэлд нь АйВиЭн-ийн Санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) шууд төлөхийг Компанид энэхүү Гэрээгээр эргэлт буцалтгүйгээр чиглэл болгож байна.</p> | <p>(b) For the purposes of clause 10.4(a), SHC hereby gives an irrevocable direction to the Company to pay all of its entitlement to Dividends directly to the IVN Provider (or to IVN or OTN on behalf of the IVN Provider, if the Ivanhoe Shareholders direct) until such time as all of the Outstanding Balance is repaid, in accordance with clause 14.2.</p> |
| <p>(в) ТӨК-аас энэхүү Гэрээний 10.4-г заасны дагуу төлсөн аливаа төлбөрийг Үлдэгдэл төлбөрийг бууруулах зорилгоор АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид төлсөн төлбөрт тооцох бөгөөд эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс уг төлбөрийг АйВиЭн, эсхүл ОТН-д төлсөн, эсхүл хүлээн авсан Ногдол ашиг гэж үзэхгүй.</p> | <p>(c) Any amount paid pursuant to this clause 10.4 will constitute a payment made by SHC to the IVN Provider to reduce the Outstanding Balance and, for the avoidance of doubt, will not be treated as a Dividend paid to, or received by, IVN or OTN.</p> |
| <p>(г) ТӨК нь энэхүү Гэрээний 10.4(а)-аас 10.4(в)-д (10.4(в)-г оролцуулж тооцно) заасан зохицуулалтын дагуу Үлдэгдэл төлбөрийг буцаан төлөхөөс гадна Санхүүжилтийн хугацаа дууссаны дараа АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) шууд төлбөр хийх замаар Үлдэгдэл төлбөрийг бууруулж болно. Талууд ийм төлбөр хийх болон хүлээн авах хамгийн тохиромжтой аргыг харилцан тохиролцоно.</p> | <p>(d) In addition to the repayment of the Outstanding Balance achieved through the arrangement described in clauses 10.4(a) to 10.4(c) (inclusive), SHC may, after the Funding Period, reduce the Outstanding Balance by making payments directly to the IVN Provider (or to IVN or OTN on behalf of the IVN Provider, if the Ivanhoe Shareholders direct), and the Parties will agree on the most appropriate method for the making and receipt of such payments.</p> |
| <p>(д) ТӨК, эсхүл Монгол Улсын Засгийн газар нь Үлдэгдэл төлбөрийн аль ч хэсгийг өөрийн эд хөрөнгөөр хариуцахгүй болохыг Талууд харилцан тохиролцов.</p> | <p>(e) The Parties agree that no recourse will be had to the assets of SHC or the Government of Mongolia in respect to any portion of the Outstanding Balance.</p> |

| | |
|--|--|
| <p>11. Давуу эрхийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийх</p> | <p>11. Preferred equity funding</p> |
| <p>11.1 Санхүүжүүлэх хувьцаа</p> <p>Санхүүжилтийн хугацаанд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид давуу эрхийн хувьцаа гаргах замаар санхүүжилт хийхээр тодорхойлсон тохиолдолд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нийт Шаардсан мөнгөн хөрөнгийг бүрэн хэмжээгээр төлөх бөгөөд Талууд дараахь зүйлсийг харилцан тохиролцов. Үүнд:</p> <p>(a) ТӨК нь энэхүү хөрөнгийг нийлүүлэх үүрэг хүлээхгүй;</p> <p>(б) Энэхүү Гэрээний 11-д заасны дагуу Компанийн гаргасан Санхүүжүүлэх хувьцааг АйВиЭн, ОТН, эсхүл АйВиЭн буюу ОТН-ийн томилсон этгээдэд (үүнд Рио Тинто Групп, эсхүл Айвенхоу Группийн аливаа гишүүн хамаарна) олгоно.</p> <p>11.2 Санхүүжүүлэх хувьцаа гаргах</p> <p>Компани нь Санхүүжүүлэх хувьцааг энэхүү Гэрээний 11.1-д заасан Шаардсан мөнгөн хөрөнгө тус бүрийн нийт үнэтэй тэнцэх тоо ширхэгээр аливаа Барьцаагүйгээр гаргана. Компани нь тухайн Санхүүжүүлэх хувьцааг гаргах, эрх олгоход шаардлагатай бүх ажлыг хийж гүйцэтгэнэ.</p> <p>11.3 Санхүүжүүлэх хувьцаанд ногдол ашиг тооцох</p> <p>(a) Компани нь Санхүүжүүлэх бүх хувьцаанд улирал тутам ногдол ашиг төлнө. Ногдол ашиг төлөөгүй тохиолдолд түүнийг хуримтлуулж тооцно.</p> <p>(б) Санхүүжүүлэх хувьцаа бүрийн ногдол ашгийг АНУ-ын улирал бүрийн Хэрэглээний Үнийн Индексээр тохируулсан Санхүүжилтийн хүүгийн хувийг тухайн Санхүүжүүлэх хувьцааны нэгжийн нэрлэсэн үнэ болон төлөгдөөгүй хийгээд хуримтлагдсан ногдол ашгийн нийт дүнгийн нийлбэрээр үржүүлэн тооцож</p> | <p>11.1 Funding Shares</p> <p>During the Funding Period, where the Ivanhoe Shareholders determine that funding will be made by way of preferred equity, the IVN Provider must contribute the whole of all Called Sums, and the Parties agree that:</p> <p>(a) SHC shall not be entitled to make any such contribution; and</p> <p>(b) Funding Shares in the Company must be issued to IVN, OTN or an IVN or OTN nominated entity (including any member of the Rio Tinto Group or the Ivanhoe Group) as provided for in this clause 11.</p> <p>11.2 Issue of Funding Shares</p> <p>The Company shall issue that number of Funding Shares corresponding to the value of the whole of each Called Sum described in clause 11.1, free of all Pledges, and the Company must do everything necessary to authorise and issue the Funding Shares.</p> <p>11.3 Calculation of dividends on Funding Shares</p> <p>(a) Dividends are payable quarterly by the Company on all Funding Shares. Where such dividends are not paid, they shall accrue.</p> <p>(b) The dividend on a Funding Share shall be calculated by multiplying the Quarterly US CPI Adjusted Carry Rate by the aggregate of the par value of such Funding Share and the value of any unpaid and accrued dividends.</p> |

| | |
|---|--|
| <p>гаргана.</p> <p>(в) Энэхүү Гэрээний 11.3(б)-д заасны дагуу тооцох Санхүүжүүлэх хувьцааны ногдол ашгийг улирал бүр нэгтгэж тооцно.</p> <p>(г) Санхүүжүүлэх хувьцааны ногдол ашгийг өнгөрсөн өдрүүдийн бодит тоо болон 360 (гурван зуун жар)-н өдөр бүхий жилээр үндэслэн тооцно. Хуанлийн улирал нь Ажлын өдөр дуусаагүй тохиолдолд тухайн хуанлийн улирлыг дараагийн Ажлын өдөр хүртэл сунгаж тооцно.</p> | <p>(c) Dividends on Funding Shares, as calculated in accordance with clause 11.3(b), shall compound quarterly.</p> <p>(d) Funding Share dividends will be computed on the basis of the actual number of days elapsed and a year of 360 days. If a calendar quarter ends on a day which is not a Working Day, that calendar quarter will be extended to the next Working Day.</p> |
| <p>11.4 Санхүүжүүлэх хувьцааг тэргүүн ээлжинд эргүүлэн худалдаж авах</p> <p>Энэхүү Гэрээний 11.1-д заасан Санхүүжүүлэх хувьцааг Компани Ногдол ашиг хуваарилж эхлэхээсээ өмнө энэхүү Гэрээний 14.1(г)-д заасны дагуу эргүүлэн худалдаж авна.</p> | <p>11.4 Priority redemption of Funding Shares</p> <p>In accordance with clause 14.1(d), Funding Shares provided under clause 11.1 must be redeemed before the Company commences paying Dividends.</p> |
| <p>11.5 Санхүүжүүлэх хувьцааны үндсэн шинж</p> <p>(a) Санхүүжүүлэх хувьцаа бүрийн нэрлэсэн үнийг ТУЗ тогтооно.</p> <p>(б) Санхүүжүүлэх хувьцаа эзэмшигч нь:</p> <p>(i) тухайн хувьцаандаа ногдох ногдол ашгийг авах эрхтэй бөгөөд Хувьцаа эзэмшигчдэд Ногдол ашиг хуваарилахаас өмнө Компаниас Санхүүжүүлэх хувьцааг эргүүлэн авахыг шаардах эрхтэй;</p> <p>(ii) Хувь нийлүүлэгчдийн хурал дээр зөвхөн дараахь асуудлаар санал өгөх эрхтэй. Үүнд:</p> <p>(A) Санхүүжүүлэх хувьцаа эзэмшигчийн эрхийг хязгаарлах нэмэлт, өөрчлөлтийг Компанийн дүрэмд оруулах, эсхүл ийм заалттай Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;</p> <p>(B) Санхүүжүүлэх хувьцааг Хувьцаанд, эсхүл бусад үнэт цаас болон эд хөрөнгөд хөрвүүлэх шаардлагатайгаар Компанийг өөрчлөн байгуулах;</p> | <p>11.5 Nature of Funding Shares</p> <p>(a) The par value of each Funding Share shall be determined by the Board of Directors.</p> <p>(b) The holder of Funding Shares:</p> <p>(i) shall have the right to receive dividends with respect to such shares, and the right to have such Funding Shares redeemed, before Dividends are distributed to the holders of Shares;</p> <p>(ii) shall have the right to vote at a Shareholders' meeting only with respect to:</p> <p>(A) adoption of amendments to, or a new version of the Company's charter, that limit the rights of the holder of Funding Shares; and</p> <p>(B) any reorganization of the Company requiring conversion of Funding Shares into Shares or other securities or property; and</p> |

| | |
|--|--|
| <p>(iii) Өөрийн Санхүүжүүлэх хувьцаа (эсхүл өөрийн Санхүүжүүлэх хувьцааны нийт, эсхүл аль нэг хэсгийн сонирхол)-г бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Хувь нийлүүлэгчдээс урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр Захиран зарцуулж болно.</p> <p>(в) Компани татан буугдсан тохиолдолд Хувьцаатай холбоотой аливаа төлбөрийг хийхээс өмнө татан буугдах үеийн үнэ хийгээд уг хувьцаанд хуримтлагдсан гэхдээ төлөгдөөгүй байгаа ногдол ашгийн нийт дүнг Санхүүжүүлэх хувьцаа эзэмшигчдэд Компани төлнө.</p> <p>(г) Хувьцааг тэргүүн ээлжинд худалдан авах эрх нь Санхүүжүүлэх хувьцааг Захиран зарцуулахад үйлчлэхгүй.</p> <p>(д) Санхүүжүүлэх хувьцааны татан буугдах үеийн үнэ нь тэдгээрийн нэрлэсэн үнийн дүн болон төлөгдөөгүй хийгээд хуримтлагдсан ногдол ашгийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.</p> <p>11.6 Үл хязгаарлах</p> <p>Энэхүү Гэрээний Санхүүжүүлэх хувьцаа гаргахтай холбоотой аливаа заалт нь Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу давуу эрхийн бусад хувьцаа гаргах Компанийн боломжийг хязгаарлахгүй боловч ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээг бууруулахад нөлөөлөхүйц, Хувьцаанд шилжих давуу эрхийн аливаа хувьцааг Компани гаргаж болохгүй.</p> | <p>(iii) may Dispose of all or any of its Funding Shares (or any interest in all or any of its Funding Shares) without the prior consent of the Shareholders.</p> <p>(c) In the case of a liquidation of the Company, the Company shall pay to the holders of Funding Shares the liquidation value and accumulated but unpaid dividends with respect to their Funding Shares before making any payments with respect to Shares.</p> <p>(d) No pre-emptive rights shall apply to the Disposal of Funding Shares.</p> <p>(e) The liquidation value of Funding Shares shall be equivalent to the aggregate of their par value and the value of any unpaid and accrued dividend.</p> <p>11.6 No limitation</p> <p>Nothing in this Agreement relating to the issue of Funding Shares shall limit the Company's ability to issue other preferred shares in accordance with the Company Law of Mongolia, provided that the Company shall not issue any preferred shares which convert to Shares and which would have the effect of diluting SHC's Percentage Interest.</p> |
| <p>12. АйВиЭн-ийн санхүүжүүлэгчээс өрийн санхүүжилт хийх</p> <p>12.1. Хувь нийлүүлэгчийн өр</p> <p>Санхүүжилтийн хугацаанд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид санхүүжилтийг Хувь нийлүүлэгчдээс олгох өрийн хэлбэрээр нийлүүлэхээр шийдсэн тохиолдолд АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь нийт Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэх ёстой бөгөөд Талууд</p> | <p>12. Debt funding by the IVN Provider</p> <p>12.1 Shareholder Debt</p> <p>During the Funding Period, where the Ivanhoe Shareholders determine that funding will be made by way of debt provided by Shareholders, the IVN Provider must contribute the whole of all Called Sums, and the Parties agree that:</p> |

| | |
|--|---|
| <p>дараахь зүйлсийг харилцан тохиролцов:</p> <p>(a) санхүүжилт нь зөвхөн АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) төлөх Хувь нийлүүлэгчийн өр байна;</p> <p>(б) хүүг Хувь нийлүүлэгчийн өр болон хуримтлагдсан аливаа хүүгийн нийлбэр дүнгээс улирал тутам тооцох бөгөөд ингэж тооцохдоо хуанлын улирал бүрийн хувьд тухайн улирал дахь АНУ-ын улирал бүрийн Хэрэглээний Үнийн Индексээр тохируулсан Санхүүжилтийн хүүг хэрэглэнэ;</p> <p>(в) хүү улирал тутам хуримтлагдах бөгөөд АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн өгсөн үндсэн зээлийн дүн дээр тухайн үе хүртэлх хуримтлагдсан хүүгээс тухайн хугацааг хүртэл Компанийн буцаан төлсөн нийт төлбөрийг хассан дүнг нэмж тооцно. Компани болон АйВиЭн-ийн санхүүжүүлэгч нь Хувь нийлүүлэгчийн өрийн нөхцөлийг баримтжуулах зорилгоор зээлийн тусгайлсан гэрээг нэн даруй байгуулна.</p> <p>(г) Хүүг өнгөрсөн өдрүүдийн бодит тоо болон 360 (гурван зуун жар)-н өдөр бүхий жилээр үндэслэн тооцно. Хуанлийн улирал нь Ажлын өдөр дуусаагүй тохиолдолд тухайн хуанлийн улирлыг дараагийн Ажлын өдөр хүртэл сунгаж тооцно.</p> <p>12.2. Хувь нийлүүлэгчийн өрийг тэргүүн ээлжинд төлөх</p> <p>Компани (энгийн хувьцаанд) Ногдол ашиг хуваарилахаас өмнө энэхүү Гэрээний 12.1-д заасан Хувь нийлүүлэгчийн өрийг энэхүү Гэрээний 14.1(г)-д заасны дагуу буцаан төлнө.</p> | <p>(a) the contribution will constitute a Shareholder Debt payable only to the IVN Provider (or to IVN or OTN on behalf of the IVN Provider, if the Ivanhoe Shareholders direct);</p> <p>(b) interest shall be calculated on the aggregate of the Shareholder Debt and any accrued interest, and accrued on a quarterly basis using, in respect of each quarter, the Quarterly US CPI Adjusted Carry Rate for that calendar quarter;</p> <p>(c) interest will compound quarterly and be calculated on principal amounts advanced by the IVN Provider plus accrued interest to that point in time less all repayments made by the Company to that point in time. A separate loan agreement shall be promptly entered into by the Company and the IVN Provider to record the terms of Shareholder Debt; and</p> <p>(d) interest will be computed on the basis of the actual number of days elapsed and a year of 360 days. If a calendar quarter ends on a day which is not a Working Day, that calendar quarter will be extended to the next Working Day.</p> <p>12.2 Priority repayment of Shareholder Debt</p> <p>In accordance with clause 14.1(d), Shareholder Debt provided under clause 12.1 must be repaid before the Company commences paying Dividends (on common shares).</p> |
| <p>13. Төслийн санхүүжилтийг гуравдагч этгээдээс авах</p> <p>(a) Компанийн төлөвлөгдсөн мөнгөн хөрөнгийн хэрэгцээг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагаас</p> | <p>13. Third party project financing</p> <p>(a) The Board of Directors may, from time to time, resolve to fund the projected cash requirements of the Company by means of borrowings by the Company</p> |

| | |
|---|---|
| <p>Компани зээл авах замаар санхүүжүүлэх шийдвэрийг ТУЗ тухай бүр гаргаж болно.</p> <p>(б) Энэхүү Гэрээний 13(а)-д заасны дагуу босгосон хөрөнгийг олон улсын банкны зах зээлд төслийн санхүүжилт олгодог хамгийн сайн нөхцөлөөр авч, албан ёсоор баримтжуулна.</p> <p>(в) Хувь нийлүүлэгч бүр Энэхүү Гэрээний 13(а)-д заасан санхүүжилтийг олж авахын тулд нөгөө талдаа болон Компанид зохих бүх дэмжлэгийг үзүүлэх бөгөөд санхүүжилтийн аливаа зохицуулалт нь Монгол Улсын Засгийн газрын, эсхүл ТӨК-ийн өмч хөрөнгөд нөлөөлөхгүй.</p> | <p>from internationally recognised financial institutions.</p> <p>(b) Any funds raised under clause 13(a) must be provided on the best terms that can be reasonably obtained in the international banking market for project finance and formally documented.</p> <p>(c) Each of the Shareholders acknowledges that it shall provide and procure all reasonable assistance to the other and the Company in order to obtain funds as contemplated by clause 13(a), provided that there shall be no recourse to the assets of SHC or the Government of Mongolia as a result of any financing arrangements.</p> |
| <p>14. Ногдол ашиг хуваарилах</p> <p>14.1 Ногдол ашиг төлөх</p> <p>(а) Хэрэв тухайн Санхүүгийн жилд Компани нь Ногдол ашиг хуваарилахаар ашигтай ажилласан бол ТУЗ нь тэрхүү ашгийн 50 (тавь)-иас доошгүй хувийг тус Санхүүгийн жил дууссанаас хойш 3 (гурав)-н сарын дотор мөнгөн хэлбэрээр Ногдол ашиг болгон хуваарилахаар зарлана. Ийнхүү зарлахдаа энэхүү Гэрээний 14.1(г), 14.2(в), түүнчлэн энэхүү Гэрээний 13-т заасан төслийн санхүүжилтийг гуравдагч этгээдээс авсан нөхцөлийн дагуу хүлээсэн үүргийг тус тус харгалзан энэхүү Гэрээний 14-д заасан бусад заалтыг баримтална. Ийнхүү хуваарилахдаа, Компанийн ирээдүйн бэлэн мөнгөний хэрэгцээ (үүнд, болзошгүй өргөтгөлийн зардал, эргэлтийн болон үндсэн хөрөнгийн зардал, бусад бодит болон нөхцөлт өр төлбөрт шаардагдах хөрөнгө)-г хангахад хүрэлцэхүйц зохистой хэмжээний нөөц авч үлдэнэ.</p> <p>(б) Энэхүү Гэрээний 14.1(а)-д заасан Ногдол ашиг болгон хуваарилах ашгийг аудит хийлгэсэн Компанийн жилийн үр дүнд тулгуурлан тогтоох бөгөөд ингэхдээ энэхүү Гэрээний 14.1(г)-д заасан шаардлагыг урьдчилан хангасан байна.</p> | <p>14. Dividend distribution</p> <p>14.1 Payment of Dividends</p> <p>(a) Subject to the other provisions of this clause 14 (including, without limitation, clause 14.1(d) and clause 14.2(c)) and the commitments provided under the terms of any third party project financing contemplated by clause 13, if, in respect of any Financial Year of the Company, the Company has profits available for distribution, the Board of Directors shall declare that at least 50% of those profits must be distributed by way of cash Dividends within 3 months after the end of that Financial Year, subject to the retention of reasonable and proper reserves for the Company's future cash requirements (including potential expansions, working capital, and the maintenance of funds for capital costs and other actual or contingent liabilities).</p> <p>(b) The profits available for distribution of Dividends referred to in clause 14.1(a) will be based on the audited annual results of the Company and subject to prior satisfaction of the requirements of clause 14.1(d).</p> |

| | |
|---|---|
| <p>(в) ТУЗ нь явцын дунд Ногдол ашиг хуваарилахаар зарлаж болно.</p> <p>(г) Энэхүү Гэрээний бусад заалтаас үл хамааран Компани нь дараахь үүргүүдийг дор дурдсан дарааллаар биелүүлээгүй тохиолдолд болон биелүүлж дуусах хүртэл Ногдол ашиг (энгийн хувьцаанд) хуваарилахгүй. Үүнд:</p> <p>(i) Энэхүү Гэрээний 13-т заасан гуравдагч этгээдийн зээлийг тухайн гуравдагч этгээдийн шаардсаны дагуу эхний ээлжинд буцаан төлөх;</p> <p>(ii) Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийг Компани бүрэн төлсөн байх;</p> <p>(iii) Энэхүү Гэрээний 12-т заасан Хувь нийлүүлэгчийн өрд тооцох аливаа хүү болон Санхүүжүүлэх хувьцаанд ногдох бүх ногдол ашгийг Компани бүрэн төлсөн байх (дараалал нь нэг байна);</p> <p>(iv) Энэхүү Гэрээний 12-т заасан Хувь нийлүүлэгчийн өрийн бүх үндсэн өрийг Компани бүрэн буцаан төлсөн байх болон бүх Санхүүжүүлэх хувьцааны хөрөнгийг Компани эргүүлэн авсан байх (дараалал нь нэг байна);</p> <p>(v) давуу эрхийн хувьцаанд ногдох (Санхүүжүүлэх хувьцаанаас бусад) бүх ногдол ашгийг Компани бүрэн төлсөн байх, мөн давуу эрхийн нийт хувьцааг (Санхүүжүүлэх хувьцаанаас бусад) Компани эргүүлэн авсан байх.</p> | <p>(c) The Board of Directors is entitled to declare interim Dividends.</p> <p>(d) Notwithstanding any other provision of this Agreement, Dividends (on common shares) are not payable by the Company unless and until the Company has discharged the following obligations, which shall be discharged in the following order of priority:</p> <p>(i) third party borrowings described in clause 13, in the priority for repayment of such borrowings required by the third party;</p> <p>(ii) the Existing Shareholder Loan has been repaid in full by the Company;</p> <p>(iii) (ranking equally) any interest on Shareholder Debt provided under clause 12, and all dividends on Funding Shares, have been paid in full by the Company;</p> <p>(iv) (ranking equally) all principal of Shareholder Debt provided under clause 12 has been repaid in full by the Company, and the redemption of the capital of all Funding Shares by the Company; and</p> <p>(v) all dividends on all preferred shares (other than Funding Shares) have been paid in full by the Company, and all preferred shares (other than Funding Shares) have been redeemed by the Company.</p> |
| <p>14.2 ТӨК-д төлөх Ногдол ашгаас суутгах</p> <p>(a) Энэхүү Гэрээний 10-т заасан Үлдэгдэл төлбөрийг (хэрэв үлдэгдэл төлбөр байгаа бол) буцаан төлөөгүй бол Компаниас аливаа Ногдол ашгийг ТӨК-д төлөхдөө дараахь дарааллыг эн тэргүүнд баримтална:</p> <p>(i) эхлээд Үлдэгдэл төлбөрийг буцаан төлөх;</p> <p>(ii) дараа нь ТӨК-д төлөх.</p> <p>(б) Компани нь энэхүү Гэрээний 14.2(a)(i)-д заасны дагуу АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид Үлдэгдэл төлбөр төлөх нь ТӨК-д Ногдол ашиг төлөх үүргээ биелүүлж байгаатай ижилд тооцогдоно.</p> | <p>14.2 Application of Dividends payable to SHC</p> <p>(a) To the extent (if any) that the Outstanding Balance under clause 10 has not been repaid, any Dividends payable by the Company to SHC must be applied in the following order of priority:</p> <p>(i) first, to the repayment of the Outstanding Balance; and</p> <p>(ii) secondly, to SHC.</p> <p>(b) The payment by the Company of such amounts to the IVN Provider of the Outstanding Balance under clause 14.2(a)(i) shall be treated as discharging the obligation of the Company to pay that amount of Dividends to SHC.</p> |

| | |
|--|--|
| <p>(в) Талууд өөрөөр тохиролцоогүй бол энэхүү Гэрээнд заасан хуваарилах зохицуулалтын дагуу Ногдол ашгийг хуваарилах нөхцөлийг хангах зорилгоор ТӨК нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.8-д заасан өөрт ногдох Ногдол ашгаа дайчлах эрхээ хэрэгжүүлэхгүй.</p> | <p>(c) Unless otherwise agreed by the Parties, and to ensure that Dividends are distributed in accordance with the distribution arrangements contained in this Agreement, SHC agrees that it will not exercise or give effect to the entitlement to mobilize its Dividends set out in Article 21.8 of the Corporate Income Tax Law.</p> |
| <p>15. Хувьцаа шилжүүлэх</p> | <p>15. Transfer of Shares</p> |
| <p>15.1 Хувьцаа шилжүүлэх зөвшөөрөл</p> <p>Энэхүү Гэрээнд (Гэрээний 15.3-д заасныг оролцуулан) тусгайлан заагаагүй бол аль нэг Хувь нийлүүлэгч нь бусад Хувь нийлүүлэгч (цаашид “Бусад Хувь нийлүүлэгч” гэх) нэг бүрийн зөвшөөрлийг урьдчилан бичгээр авахгүйгээр өөрийн Хувьцаагаа бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн (эсхүл өөрийн бүх Хувьцаа болон түүний тодорхой хэсэг Хувьцаанд ногдох ашиг сонирхлыг) Захиран зарцуулахгүй.</p> <p>15.2 Тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг Хувьцаа шилжүүлэх үед хэрэглэх</p> <p>(a) Хэрэв Хувьцааг энэхүү Гэрээний 15.2(б)-ээс (и)-д ((и)-г оруулж тооцно) заасны дагуу шилжүүлэх бол энэхүү Гэрээний 15.3 болон 15.7-д заасныг баримтлан Хувь нийлүүлэгч нь өөрийн Хувьцааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.</p> <p>(б) Хэрэв Шилжүүлэгч нь өөрийн Хувьцааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хүсвэл (цаашид “Захиран зарцуулах хувьцаа” гэх) уг Захиран зарцуулах хувьцаагаа Бусад Хувь нийлүүлэгч нэг бүрт тэргүүн ээлжинд санал болгоно.</p> <p>(в) Энэхүү Гэрээний 15.2(б)-д заасны дагуу Шилжүүлэгч нь шилжүүлэх аливаа саналаа бичгээр (цаашид “Шилжүүлэх мэдэгдэл” гэх) гаргах бөгөөд Шилжүүлэх мэдэгдэлд дараахь зүйлсийг тусгана:</p> | <p>15.1 Consent to transfer Shares</p> <p>Except as expressly provided in this Agreement (including clause 15.3), a Shareholder shall not Dispose of all or any of its Shares (or any interest in all or any of its Shares) unless it has received the prior written consent of each of the other Shareholders (<i>Other Shareholders</i>).</p> <p>15.2 Pre-emptive rights applicable on transfer of Shares</p> <p>(a) Subject to clauses 15.3 and 15.7, a Shareholder may transfer all or any of its Shares if the transfer is conducted in accordance with the provisions of clauses 15.2(b) to (j) (inclusive).</p> <p>(b) If a Transferor wishes to transfer all or any of its Shares to a third party (<i>Disposal Shares</i>), it must first offer the Disposal Shares to each of the Other Shareholders.</p> <p>(c) Any offer made by a Transferor pursuant to clause 15.2(b) must be made pursuant to a written notice (<i>Transfer Notice</i>). A Transfer Notice must:</p> |

| | |
|---|--|
| <p>(i) Захиран зарцуулах хувьцааны тоо болон Захиран зарцуулах хувьцааны үнийг ам.доллараар (Шилжүүлэх үнэ);</p> <p>(ii) Захиран зарцуулах хувьцааг худалдахаар санал болгож буй нөхцөл;</p> <p>(iii) Шилжүүлэгчийн саналыг Бусад Хувь нийлүүлэгч хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд Шилжүүлэгчээс Захиран зарцуулах хувьцаагаа худалдахаар санал болгож буй гуравдагч этгээд (цаашид “Сонгогдсон гуравдагч этгээд” гэх)-ийн тухай.</p> <p>(г) Шилжүүлэх мэдэгдэл нь түүнд заасан нөхцөлийн дагуу Захиран зарцуулах хувьцааг ямар нэг нөхцөл, болзолгүйгээр худалдах санал болох бөгөөд Шилжүүлэх мэдэгдлийг Бусад Хувь нийлүүлэгчдэд хүргүүлсэн өдрөөс хойш 50 (тавь)-н Ажлын өдрийн дотор уг саналд Бусад Хувь нийлүүлэгч хариу өгөхөд нээлттэй байна (цаашид “Санал гаргах хугацаа” гэх).</p> <p>(д) Санал гаргах хугацаанд Бусад Хувь нийлүүлэгчийн аль нэг нь Шилжүүлэх мэдэгдэлд санал болгосон Захиран зарцуулах хувьцааг бүхэлд нь худалдан авахаас татгалзаж байгаагаа, эсхүл саналыг хүлээн авч байгаагаа Шилжүүлэгчид бичгээр мэдэгдэж болно (ингэхдээ мэдэгдлийн хувийг Бусад Хувь нийлүүлэгчдэд хүргүүлнэ). Хэрэв 1 (нэг)-ээс дээш Бусад Хувь нийлүүлэгч байгаа бол Захиран зарцуулах хувьцааг тэдгээрт тус бүрт нь санал болгосонд тооцно. Хэрэв 1 (нэг)-ээс дээш Хувь нийлүүлэгч худалдаж авахаар зөвшөөрвөл (хамтдаа биш, харин тус тусдаа) тэдгээр нь Захиран зарцуулах хувьцааг тэдгээрийн нийт Эзэмшлийн хувь хэмжээн дэх өөрсдийн Эзэмшлийн хувь хэмжээнд тохируулан (эсхүл тэдгээр Бусад Хувь нийлүүлэгч өөрөөр тохирч Шилжүүлэгчид бичгээр мэдэгдсэн өөр хувь хэмжээгээр) худалдан авна.</p> | <p>(i) specify the number of Disposal Shares and the cash price in USD for the Disposal Shares (<i>Transfer Price</i>);</p> <p>(ii) contain the terms upon which the Disposal Shares are offered for sale; and</p> <p>(iii) specify the third party to whom the Transferor proposes to sell the Disposal Shares in the event that the Other Shareholders do not accept the offer of the Transferor (<i>Nominated Third Party</i>).</p> <p>(d) A Transfer Notice constitutes an unconditional offer to sell the Disposal Shares, upon the terms set out in the Transfer Notice, which offer must remain open for acceptance by each of the Other Shareholders until the expiry of 50 Working Days after the date of service of the Transfer Notice on the Other Shareholders (<i>Offer Period</i>).</p> <p>(e) At any time during the Offer Period, any of the Other Shareholders may by notice in writing to the Transferor (with a copy to be provided to the other Shareholders) reject or accept in full the Disposal Shares offered in a Transfer Notice. If there is more than one Other Shareholder, the Disposal Shares will be deemed to be offered to each of them. If more than one accepts they will purchase (severally and not jointly) the Disposal Shares in the proportions that their respective Percentage Interests bear to the aggregate of their Percentage Interests (or in any other proportions as those Other Shareholders agree and notify in writing to the Transferor).</p> |
|---|--|

| | |
|---|---|
| <p>(e) Хэрэв аль 1 (нэг), эсхүл түүнээс дээш Бусад Хувь нийлүүлэгч Захиран зарцуулах хувьцааг худалдах саналыг хүлээн зөвшөөрөөгүй бол үлдсэн Бусад Хувь нийлүүлэгч, эсхүл Хувь нийлүүлэгчид тэдгээрийн нийт Эзэмшлийн хувь хэмжээн дэх өөрсдийн Эзэмшлийн хувь хэмжээнд тохируулан (эсхүл тэдгээр Бусад Хувь нийлүүлэгч өөрөөр тохирч Шилжүүлэгчид мэдэгдсэн хувь хэмжээгээр) Захиран зарцуулах хувьцааг худалдах саналыг хүлээн зөвшөөрч болно.</p> <p>(ё) Хэрэв аль 1 (нэг), эсхүл түүнээс дээш Бусад Хувь нийлүүлэгч нь бүх Захиран зарцуулах хувьцааг энэхүү Гэрээний 15.2(д) болон 15.2(е)-д заасан зохицуулалтын хэрэгжилтийн дараагаар, Санал гаргах хугацаа дуусахад хүлээн зөвшөөрөөгүй бол Шилжүүлэх мэдэгдэлд дурдсан саналаас татгалзсанд тооцно.</p> <p>(ж) Аливаа шаардлагатай зөвшөөрөл авахаас бусад тохиолдолд энэхүү Гэрээний 15.2(б)-д заасны дагуу саналыг хүлээн зөвшөөрөх нь ямар нэг болзолгүй байна.</p> <p>(з) Хэрэв 1 (нэг), эсхүл түүнээс дээш Бусад Хувь нийлүүлэгч нь бүх Захиран зарцуулах хувьцааг худалдаж авахаар зөвшөөрвөл Санал гаргах хугацааны сүүлчийн өдрөөс хойшхи 10 (арав) дахь Ажлын өдөр Шилжүүлэгч нь Захиран зарцуулах хувьцааг Шилжүүлэх үнээр худалдаж, холбогдох Бусад Хувь нийлүүлэгч, эсхүл Хувь нийлүүлэгчид худалдан авч Захиран зарцуулах хувьцааг шилжүүлж дуусгана.</p> <p>(и) Энэхүү Гэрээний 15.2(б)-ээс (ж)-д ((ж)-г оруулж тооцно) заасныг мөрдсөн боловч Захиран зарцуулах хувьцааг худалдан авах саналыг хүлээн авах санал ирээгүй бол энэхүү Гэрээний 15.7-д заасныг баримтлан Шилжүүлэгч нь Санал гаргах хугацаа дууссанаас хойш 90 (ер) хоногийн дотор Захиран зарцуулах хувьцаагаа хэсэгчилэхгүйгээр бүхэлд нь Сонгогдсон гуравдагч этгээдэд Шилжүүлэх үнээс доошгүй үнээр, Шилжүүлэх мэдэгдэлд заасан нөхцөлөөс илүүгүй нөхцөлөөр шилжүүлж болно.</p> <p>(к) Санал гаргах хугацаа дууссанаас хойш 90 (ер) хоногийн дотор</p> | <p>(f) If one or more Other Shareholders do not accept the offer made in respect of the Disposal Shares, the remaining Other Shareholder or Other Shareholders may accept the offer in respect of all of the Disposal Shares in the proportions that their respective Percentage Interests bear to the aggregate of their Percentage Interests (or in any other proportions as those Other Shareholders agree and notify to the Transferor).</p> <p>(g) If any one or more of the Other Shareholders do not accept all of the Disposal Shares following the application of the provisions of clauses 15.2(e) and 15.2(f), by the expiry of the Offer Period, the offer in the Transfer Notice is deemed to have been rejected.</p> <p>(h) Acceptances of offers made pursuant to clause 15.2(b) must be unconditional other than any necessary authorisations.</p> <p>(i) If any one or more of the Other Shareholders accept all of the Disposal Shares, the transfer of the Disposal Shares must be completed on the tenth Working Day after the last day of the Offer Period, when the Transferor must sell and the applicable Other Shareholder or Other Shareholders must purchase the Disposal Shares at the Transfer Price.</p> <p>(j) If acceptances are not received in respect of all of the Disposal Shares following compliance with clauses 15.2(b) to (h) (inclusive), the Transferor may, subject to clause 15.7, at any time within 90 days after the expiry of the Offer Period transfer all but not some of the Disposal Shares to the Nominated Third Party, at a cash price only that must not be less than the Transfer Price and on terms no more favourable to the Nominated Third Party than as set out in the Transfer Notice.</p> <p>(k) If the transfer of all of the Disposal Shares does not occur within 90 days after the expiry of the Offer Period, the Transferor may not</p> |
|---|---|

Захиран зарцуулах хувьцааг шилжүүлээгүй бол Шилжүүлэгч нь энэхүү Гэрээний 15.2(б)-ээс (ж)-д ((ж)-г оруулж тооцно) заасан шаардлагыг эхэлж хангахгүйгээр Захиран зарцуулах хувьцаагаа бусдад шилжүүлж болохгүй.

15.3 Зөвшөөрөгдсөн шилжүүлэг

- (a) Хувь нийлүүлэгч, эсхүл давуу эрхтэй хувьцаа эзэмшигч болох Айвенхоу групп, эсхүл Рио Тинто группийн аливаа гишүүн нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа, эсхүл аливаа давуу эрхийн хувьцааг (Санхүүжүүлэх хувьцааг оролцуулан) (аль холбогдох нь) аливаа бусад Хувь нийлүүлэгч, эсхүл давуу эрхийн хувьцаа эзэмшигчээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авахгүйгээр, эсхүл энэхүү Гэрээний 15.2-т заасан шаардлагыг эхэлж хангахгүйгээр тухайн группийнхээ аливаа бусад гишүүнд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.
- (б) ТӨК нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа, эсхүл аливаа давуу эрхийн хувьцааг (аль холбогдох нь) бусад Хувь нийлүүлэгчид, эсхүл давуу эрхийн хувьцаа эзэмшигчдээс урьдчилан бичгээр зөвшөөрөл авахгүйгээр Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан 100 (нэг зуу) хувь Төрийн өмчит, гагцхүү Төрийн хяналтад байдаг аливаа бусад компанид, эсхүл 15.2-д заасан шаардлагыг эхлэн хангахгүйгээр бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн шилжүүлж болно.
- (в) Хөрөнгө оруулалтын гэрээний 1.9-д заасны дагуу Ашигт малтмалын тухай хуулийн 5.6-д заасан шаардлагыг хангах үүднээс Засгийн газарт шилжүүлсэн хувьцааны 10 (арав)-аас доошгүй хувийг Монгол Улсын Хөрөнгийн бирж дээр худалдах асуудлыг ТӨК хариуцах бөгөөд ийнхүү шилжүүлэх нь энэхүү Гэрээний 15-д заасан шилжүүлгийн хязгаарлалтуудад хамаарахгүй. Хөрөнгө оруулалтын гэрээний 1.9-д заасныг хязгаарлахгүйгээр Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон Компани нь энэхүү Гэрээний 15.3(в)-д заасны дагуу ТӨК-ийн хэрэгжүүлэх үүргийг гүйцэтгүүлэхийг шаардахгүй.

transfer the Disposal Shares without first complying with the requirements of clauses 15.2(b) to (h) (inclusive).

15.3 Permitted transfers

- (a) Any member of the Ivanhoe Group or any member of the Rio Tinto Group that is a Shareholder or preferred shareholder may transfer all or part of the Shares or any preferred shares (including Funding Shares) (as applicable) held by it to any other member of the Ivanhoe Group or the Rio Tinto Group without obtaining the prior written consent of the other Shareholders or preferred shareholders, or first complying with the requirements of clause 15.2.
- (b) SHC may transfer all or part of the Shares or any preferred shares (as applicable) held by it to any other company wholly-owned by the State, duly incorporated under the Company Law of Mongolia, and Controlled solely by the State, without obtaining the prior written consent of the other Shareholders or preferred shareholders, or first complying with the requirements of clause 15.2.
- (c) In accordance with Clause 1.9 of the Investment Agreement, SHC shall be responsible for listing that proportion of the Government Issue Shares which represent not less than ten percent (10%) of the Shares in the Company on the Mongolian Stock Exchange in satisfaction of the requirements of Article 5.6 of the Minerals Law of Mongolia, and the transfer of such Shares shall be and remain exempt from the transfer restrictions of this clause 15. Without limiting Clause 1.9 of the Investment Agreement, the Ivanhoe Shareholders and the Company cannot compel performance of SHC's obligations under this clause 15.3(c).

| | |
|---|---|
| <p>15.4 Хувьцааг барьцаалах тухай</p> <p>Хувь нийлүүлэгч нь энэхүү Гэрээний 15.5-д зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн Хувьцаагаа бусдад баталгаа, барьцаа, төлбөр, үүргийн гүйцэтгэлийг хангах аливаа барьцаа (цаашид “Барьцаа” гэх)-нд тавьж үл болно.</p> <p>15.5 Хувьцааг барьцаалах</p> <p>(a) Энэхүү Гэрээний 15.5-д заасан заалт нь мөн Гэрээний 13-д тодорхойлсон аливаа барьцаа, эсхүл гуравдагч этгээдийн төслийн санхүүжилтийн зохицуулалтад (энэхүү Гэрээний 15.5-д заасан шаардлагууд нь тэрхүү санхүүжилтийг авахад шаардлагатай байсан ч) хамаарах шаардлагууд биш болохыг Талууд харилцан зөвшөөрөв;</p> <p>(б) энэхүү Гэрээний 15.5(г)-д зааснаас бусад тохиолдолд Хувь нийлүүлэгч нь зөвхөн дараахь нөхцөлд өөрийн эзэмшлийн Хувьцааг Барьцаалж болно (цаашид “Зөвшөөрөгдсөн барьцаа” гэх):</p> <p>(i) Хувьцааг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн байгууллагад энэхүү Гэрээний 13(a)-д заасан санхүүжилтийг авахтай холбогдуулан (төслийн санхүүжилтийг гуравдагч этгээдээс авахтай холбоотой) Барьцаалах (цаашид “Зөвшөөрөгдсөн барьцаалагч” гэх);</p> <p>(ii) тухайн Хувь нийлүүлэгч ТУЗ-д бичгээр урьдчилан мэдэгдсэн;</p> <p>(iii) дараахь шаардлагыг урьдчилан хангасан. Үүнд:</p> <p>A) Зөвшөөрөгдсөн барьцаа нь бичгээр үйлдэгдсэн байх бөгөөд энэхүү Гэрээний 15.5-г заасан шаардлагыг хангасан байх;</p> | <p>15.4 Mortgaging Shares</p> <p>A Shareholder must not create a mortgage, pledge, charge or other security interest (<i>Pledge</i>) in respect of its Shares unless as provided in clause 15.5.</p> <p>15.5 Pledge over Shares</p> <p>(a) The Parties agree that the requirements of this clause 15.5 are not required terms of any security or other third party project financing arrangements described under clause 13 (notwithstanding that establishing the requirements set out in this clause 15.5 may be necessary or desirable in order to obtain such finance).</p> <p>(b) Except as provided in clause 15.5(d), a Shareholder may create a Pledge in respect of its Shares (a <i>Permitted Charge</i>) only if:</p> <p>(i) the Pledge is created in favour of an internationally recognised financial institution providing financing as contemplated by clause 13(a) (relating to third party project financing) (the <i>Permitted Chargee</i>);</p> <p>(ii) the Shareholder first notifies the Board of Directors in writing; and</p> <p>(iii) the following requirements are first satisfied:</p> <p>(A) The Permitted Charge must be in writing and comply with the requirements of a Permitted Charge described in this clause 15.5.</p> |
|---|---|

| | |
|--|---|
| <p>Б) Зөвшөөрөгдсөн барьцааны хувийг бусад Хувь нийлүүлэгч нэг бүрт тухайн баримт бичгийг үйлдэхээс доод тал нь 30 (гуч)-н Ажлын өдрийн өмнө хүргүүлсэн байх бөгөөд бусад Хувь нийлүүлэгч нэг бүрийн урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр (үйлдэхээс өмнө, эсхүл дараа) түүнд ямар нэгэн өөрчлөлт оруулахгүй;</p> <p>В) Зөвшөөрөгдсөн барьцаалагч нь бусад Хувь нийлүүлэгчид хүлээн зөвшөөрөхүйц хэлбэр бүхий, төлбөрийг төлөх асуудлаарх эрх, үүргийг тодорхойлсон баримт бичиг (deed of covenant)-т гарын үсэг зурж, Компанид болон Хувь нийлүүлэгч нэг бүрт хүргүүлнэ. Төлбөрийн гэрээгээр Зөвшөөрөгдсөн барьцаалагч Зөвшөөрөгдсөн барьцаатай холбоотойгоор эдлэх эрх нь:</p> <p>(1) энэхүү Гэрээний дагуу байна;</p> <p>(2) энэхүү Гэрээний 10.4 болон 14.2-т заасны дагуу ТӨК-д төлөх Ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон АйВиЭн-ийн санхүүжүүлэгч авсны дараа нээгдэнэ гэдгийг тус тус хүлээн зөвшөөрөв.</p> <p>(в) Зөвшөөрөгдсөн барьцаа нь:</p> <p>(i) энэхүү Гэрээний дагуу Хувь нийлүүлэгчийн эдлэх аливаа эрх, эрх зүйн хамгаалалт, түүний дотор өр төлбөр (үүнд, Үлдэгдэл төлбөр багтана) хүлээн авах эрхийг хөндөх, эсхүл түүнд нөлөөлөх ёсгүй;</p> <p>(ii) Зөвшөөрөгдсөн барьцаалагч (эсхүл түүгээр дамжуулан эрх ашгаа илэрхийлж буй этгээд) нь аливаа худалдах эрхээ, эсхүл өөрийн баталгаатай холбоотой эрхээ эдлэх, эсхүл хэрэгжүүлэхдээ энэхүү Гэрээний 15 (энэхүү Гэрээний</p> | <p>(B) A copy of the Permitted Charge must be given to each other Shareholder at least 30 Working Days before it is executed and must not be amended (before or after execution) without the prior written consent of each other Shareholder.</p> <p>(C) The Permitted Chargee must sign and deliver to each Shareholder and the Company a deed of covenant in a form acceptable to the other Shareholders under which the Permitted Chargee agrees that its rights and entitlements in connection with the Permitted Charge:</p> <p>(1) are subject to this Agreement; and</p> <p>(2) must be subordinated in priority to the rights and entitlements of IVN, OTN and the IVN Provider to receive Dividends otherwise payable to SHC in accordance with clauses 10.4 and 14.2.</p> <p>(c) The Permitted Charge must:</p> <p>(i) not prejudice or affect the rights and remedies under this Agreement of any Shareholder, including the right to be repaid any sum, including the Outstanding Balance, under this Agreement;</p> <p>(ii) expressly provide that the Permitted Chargee (or any person claiming through the Permitted Chargee) in the exercise or enforcement of any power of sale or other power of its security is subject to this clause 15 (including</p> |
|--|---|

| | |
|---|--|
| <p>15.2-т заасан тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг оролцуулан)-д заасныг баримтлана;</p> <p>(iii) Энэхүү Гэрээний 10.4 болон 14.2-т заасны дагуу ТӨК-д төлөх Ногдол ашгийг АйВиЭн, ОТН болон АйВиЭн-ийн Санхүүжүүлэгч тэргүүн ээлжинд авах эрхээ эдэлсний дараа Зөвшөөрөгдсөн барьцаалагчийн эрх нээгдэнэ гэдгийг тус тус тодорхой заана.</p> <p>(г) Хувь нийлүүлэгчдээс бичгээр урьдчилан зөвшөөрөл авах болон 15.5(б) болон 15.5(в)-д заасан шаардлагууд нь энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдөр Айвенхоу групп болон Рио Тинто группын аль нэг гишүүний хоорондын аливаа Барьцаанд хамаарахгүй.</p> | <p>the rights of pre-emption in clause 15.2); and</p> <p>(iii) expressly provide that the rights of the Permitted Chargee are subordinated in priority to the rights and entitlements of IVN, OTN and the IVN Provider to receive Dividends otherwise payable to SHC in accordance with clauses 10.4 and 14.2.</p> <p>(d) Any Pledge existing at the date of this Agreement between any member of the Ivanhoe Group and any member of the Rio Tinto Group shall not require the prior written consent of the other Shareholders or compliance with the requirements of clauses 15.5(b) and 15.5(c).</p> |
| <p>15.6 ТӨК-ийн өмчлөл ба хувьцааг хөрөнгийн биржээр арилжих</p> <p>(a) Энэхүү Гэрээний 15.6(б)-д заасны дагуу Төр ТӨК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр арилжихаас бусад тохиолдолд ТӨК нь Оюу Толгой Төслийн хэрэгжих хугацааны туршид:</p> <p>(i) 100 (нэг зуу) хувь Төрийн өмчлөлд;</p> <p>(ii) Зөвхөн Төрийн хяналтад байна.</p> <p>(б) Төр нь ТӨК дахь өөрийн хувьцаагаа Монголын Хөрөнгийн бирж, эсхүл олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн биржид гарган арилжиж болно;</p> <p>(в) Хэрэв ТӨК 100 (нэг зуу) хувь Төрийн өмчлөлд болон түүний хяналтад байгаа болсон (тухайлбал ТӨК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан арилжсаны үр дүнд) тохиолдолд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид холбогдох шийдвэр гарган ТӨК-д бичгээр мэдэгдэл ирүүлмэгц тухайн үеийн аливаа Үлдэгдэл төлбөрийг АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) бүхэлд нь шууд төлөх үүрэг хүлээнэ.</p> | <p>15.6 SHC ownership and listing</p> <p>(a) SHC must remain:</p> <p>(i) wholly-owned by the State; and</p> <p>(ii) Controlled solely by the State,</p> <p>for the life of the OT Project, except as provided in clause 15.6(b) in relation to the listing of shares of SHC by the State.</p> <p>(b) The State may list its shares in SHC on the Mongolian Stock Exchange or any internationally recognised stock exchange.</p> <p>(c) If SHC ceases to be wholly-owned and Controlled by the State (including as a result of the listing of the shares in SHC) then, at the Ivanhoe Shareholders' election and on written notice from the Ivanhoe Shareholders to SHC, any Outstanding Balance at that time shall immediately become due and payable in full to the IVN Provider (or to IVN or OTN on behalf of the IVN Provider, if the Ivanhoe Shareholders direct).</p> |

15.7 Захиран зарцуулах хувьцаанд тавигдах бусад хязгаарлалт

Хувьцаа шилжүүлснийг бүртгэхээс өмнө Хувь нийлүүлэгч нь дор дурдсанаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн Хувьцааг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн Захиран зарцуулж болохгүй:

- (a) (Захиран зарцуулах хувьцааг одоогийн Хувь нийлүүлэгчид шилжүүлэхээс бусад тохиолдолд) шилжүүлэн авагч нь Шилжүүлэгчийн үүргийг бүрэн хүлээн авч биелүүлэхээ зөвшөөрөн тухайн асуудлаарх эрх, үүргийг тодорхойлсон, Талуудын хүлээн зөвшөөрхүйц хэлбэр бүхий баримт бичиг (deed of accession and assumption)-ийг Талуудтай байгуулах;
- (б) ТӨК Шилжүүлэгч байх тохиолдолд АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн сонгосноор (энэ тухай ТӨК-д бичгээр мэдэгдэнэ):
 - (i) шилжүүлэн авагч, эсхүл ТӨК нь шилжүүлэх үед аливаа Үлдэгдэл төлбөрийг бүхэлд нь төлөх, эсхүл өөртөө авах; эсхүл
 - (ii) шилжүүлэн авагч нь аливаа Үлдэгдэл төлбөрийг, эсхүл хэрэв ТӨК өөрийн бүх Хувьцаагаа шилжүүлээгүй бол Компани шилжүүлгийг бүртгэхээс өмнө Шилжүүлэгчийн эзэмшиж байсан нийт Хувьцаанд шилжүүлж байгаа Хувьцааны эзлэх хувь хэмжээтэй ижил хэмжээний Үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулах үүргийг хүлээн авах (эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс, энэхүү Гэрээний 14.2-т заасны дагуу шилжүүлэн авагч нь Ногдол ашиг авах эрхийг Үлдэгдэл төлбөрийг, эсхүл Үлдэгдэл төлбөрийн холбогдох хэсгийг бүрэн төлж барагдуулсны дараа эдэлнэ).
- (в) аливаа Шилжүүлэгчийн хувьд шилжүүлэн авагч нь шилжүүлэх үед энэхүү Гэрээний нөхцөлийн дагуу Компанид, эсхүл бусад Хувь нийлүүлэгч бүрт Шилжүүлэгчийн төлөх ёстой бүх

15.7 Further restrictions on Disposal of Shares

A Shareholder may not Dispose of all or any of its Shares (or any interest in all or any of its Shares) unless, prior to registration of the transfer of the Shares:

- (a) (except where the Disposal of Shares is to an existing Shareholder) the transferee enters into a deed of accession and assumption with the Parties in a form acceptable to the Parties agreeing to be bound by and assume the obligations of the Transferor;
- (b) in the case where SHC is the Transferor, at the IVN Provider's election (to be notified in writing to SHC), either:
 - (i) the transferee or SHC pays or procures the payment of any Outstanding Balance in full at the time of transfer; or
 - (ii) the transferee assumes the obligation to repay any Outstanding Balance or, if SHC is not transferring all its Shares, that proportion of the Outstanding Balance as is the same proportion as the number of Shares being transferred bears to the total number of Shares held by the Transferor immediately before registration of the transfer by the Company (and, for the avoidance of doubt, the Dividends to which such transferee would otherwise be entitled shall be applied in priority to the repayment of the Outstanding Balance or the relevant proportion of the Outstanding Balance, as the case may be, as contemplated by clause 14.2);
- (c) subject to clause 15.7(b), in the case of any Transferor, the transferee, at the time of transfer, pays or procures the payment to

| | |
|---|---|
| <p>төлбөрийг Гэрээний 15.7(б)-д заасныг баримтлан Компанид болон тухайн Хувь нийлүүлэгч бүрт төлөх, эсхүл өөртөө авах;</p> <p>(г) шилжүүлэн авагч нь шаардлагатай бүх зөвшөөрлийг авах.</p> <p>15.8 Хүчин төгөлдөр бус шилжүүлэг</p> <p>Энэхүү Гэрээний 15-д заасныг зөрчиж хийсэн аливаа шилжүүлгийг Компани бүртгэхгүй. Ийнхүү хийсэн шилжүүлэг нь хүчин төгөлдөр бус байна.</p> <p>15.9 Энэхүү Гэрээнд заасан эрхээ шилжүүлэх</p> <p>Энэхүү Гэрээний 15-д заасны дагуу Хувьцаа шилжүүлэхээс бусад тохиолдолд аль нэг Тал нь бусад Талуудын зөвшөөрлийг урьдчилан бичгээр авахгүйгээр энэхүү Гэрээгээр олгогдсон эрхээ бусдад шилжүүлэх буюу шилжүүлэх оролдлого хийх ёсгүй.</p> <p>15.10 Компани дахь хувь эзэмшлээ 16 хувиар нэмэгдүүлэх ТӨК-ийн опцион эрх</p> <p>(а) ТӨК нь Компанийн нийт хөрөнгөд (цаашид “Опцион эрхийн хувьцаа” гэх) эзэмших хувь хэмжээгээ нэмэгдүүлэх опцион эрх (цаашид “Опцион эрх” гэх)-тэй бөгөөд энэхүү эрхээ хэрэгжүүлснээр ТӨК нь Компанийн гаргасан нийт энгийн хувьцааны 16 (арван зургаа)-н хувийг нэмж эзэмших болно. Ингэхдээ опционыг ТӨК болон Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид харилцан зөвшөөрсөн нөхцөлөөр хэрэгжүүлнэ.</p> <p>(б) Уг Опцион эрхээ ТӨК нь Хөрөнгө оруулалтын гэрээний хугацааг тэрхүү Гэрээний 15.11-д заасны дагуу анх удаа сунгасан өдрөөс хойш 1 (нэг) жилийн дотор Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон Компанид зөвхөн бичгээр мэдэгдсэнээр л эдэлж болно.</p> <p>(в) Опцион эрхийн хувьцааг ТӨК авснаар Компани дахь Хувь нийлүүлэгчдийн Эзэмшлийн хувь хэмжээ дараахь байдалтай болно:</p> | <p>each other Shareholder and the Company of all amounts which the Transferor is obliged to pay to each other Shareholder or the Company (as the case may be) under the terms of this Agreement; and</p> <p>(d) the transferee obtains all necessary authorisations.</p> <p>15.8 Ineffective transfer</p> <p>The Company shall not register any transfer made in breach of this clause 15. Any purported transfer so made will be void and of no effect.</p> <p>15.9 Disposal of rights in this Agreement</p> <p>Without the prior written consent of the other Parties, a Party must not Dispose of any of its rights under this Agreement or attempt to do so, otherwise than in connection with a transfer of Shares in accordance with this clause 15.</p> <p>15.10 SHC option to acquire an additional 16% shareholding in the Company</p> <p>(a) SHC shall have the option (<i>Option</i>) to acquire an additional number of common shares in the capital of the Company which will, after such acquisition, result in SHC holding a further 16% of the total issued common shares in the capital of the Company (<i>Option Shares</i>), provided terms are agreed between SHC and the Ivanhoe Shareholders.</p> <p>(b) SHC may only exercise the Option by written notice to the Ivanhoe Shareholders and the Company during the period commencing on an from the date upon which the term of the Investment Agreement is first extended in accordance with Clause 15.11 of the Investment Agreement, and ending on the date which is one (1) calendar year after such date.</p> <p>(c) Immediately after the acquisition of the Option Shares to SHC, the respective Percentage Interests of the Shareholders in the Company would be as follows:</p> |
|---|---|

| | |
|--|--|
| <p>(i) ТӨК – 50 (тавь)-н хувь;</p> <p>(ii) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид - 50 (тавь)-н хувь.</p> <p>(г) Энэхүү Гэрээний 15-д заасны дагуу ТӨК Опцион эрхийн хувьцааг авснаас үл хамааран Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь Оюу Толгой төслийн менежментийн эрхийг бүрэн хэмжээгээр, хязгаарлалтгүйгээр хадгалах бөгөөд Компанийн ТУЗ-ийн бүх хурал болон Хувь нийлүүлэгчдийн бүх хуралд 4.10(a)(viii)-аас 4.10(a)(xvi) (4.10(a)(xvi)-г оруулж тооцно)-д заасан асуудлаар шийдвэрлэх саналын эрхтэй байна. Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид болон ТӨК нь энэхүү Гэрээний 15.10(г)-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Хувь нийлүүлэгчдийн гэрээнд болон бусад бичиг баримтад шаардлагатай өөрчлөлтийг хийнэ.</p> | <p>(i) SHC – 50%; and</p> <p>(ii) the Ivanhoe Shareholders – 50%.</p> <p>(d) Notwithstanding any acquisition of the Option Shares by SHC in accordance with this clause 15, the Ivanhoe Shareholders shall retain full and unrestricted management rights over the OT Project, and have a casting vote at all meetings of the Board of Directors of the Company, and at all Shareholder meetings for all matters described in clauses 4.10(a)(viii) to 4.10(a)(xvi) (inclusive), and the Ivanhoe Shareholders and SHC shall make, or shall procure the making of, all amendments to the Shareholders' Agreement and any other documents that the Ivanhoe Shareholders deem necessary to give effect to this clause 15.10(d).</p> |
| <p>16. Мэдэгдэл болон баталгаа</p> <p>(a) Гэрээний Тал тус бүр нөгөө талдаа дараахь мэдэгдэл ба баталгааг гаргаж байна. Үүнд:</p> <p>(i) тухайн Тал нь өөрийн үүсгэн байгуулагдсан улсынхаа хууль тогтоомжийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй компани мөн (ТӨК-ийн хувьд тухайн компани нь Компанийн тухай Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан бөгөөд энэ хуулийн дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна);</p> <p>(ii) энэхүү Гэрээг байгуулах болон энэхүү Гэрээнд заасан өөрийн үүргээ биелүүлэх, үйл ажиллагаагаа хэвээр явуулах, эсхүл ирээдүйд төлөвлөснөөр явуулах эрхтэй.</p> <p>(б) Компани, Хувь нийлүүлэгчид (тэдгээрийн Хамаарал бүхий компани) болон Менежментийн багийн Нууцын зэрэглэлтэй мэдээллийн хувьд ТУЗ-өөс тухай бүр тодорхойлсон нууцлалтай холбоотой үүргийг Талууд заавал дагаж мөрдөнө. ТУЗ нь энэхүү нууцлалын үүргийг тодорхойлохдоо Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу мэдээлэл гаргаж өгөх шаардлага, санхүүгийн</p> | <p>16. Representations and warranties</p> <p>(a) Each Party represents and warrants to each other Party that:</p> <p>(i) it is a corporation duly incorporated and validly existing under the laws of the place of its incorporation (and, in the case of SHC, it is duly incorporated under the Company Law of Mongolia and is and will continue to be subject to the Company Law of Mongolia); and</p> <p>(ii) it has the power to enter into and perform its obligations under this Agreement and to carry on its business as now conducted or contemplated.</p> <p>(b) Each Party must comply with the obligations of confidentiality specified by the Board of Directors from time to time in respect of Proprietary Information of the Company, the Shareholders (and their respective Related Corporations) and the Management Team. In specifying such confidentiality obligations, the Board of Directors will take into consideration the disclosure requirements under Mongolian law, financial reporting requirements and the protection of commercially sensitive information. If required by the Board of</p> |

| | |
|--|---|
| <p>тайлан гаргах шаардлага болон бизнесийн чухал мэдээллийн хамгаалалт зэргийг харгалзан үзнэ. ТУЗ-өөс шаардсан тохиолдолд Хувь нийлүүлэгч бүр өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүд, албан хаагч, ажилтан, гэрээт гүйцэтгэгч, эсхүл тэдгээрийн төлөөлөгчөөр Нууцын зэрэглэлтэй мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээлгэсэн баримт бичигт гарын үсэг зуруулна. Хувь нийлүүлэгч бүр өөрийн томилсон ТУЗ-ийн гишүүд, эсхүл Хувь нийлүүлэгчийн албан хаагч, ажилтан, гэрээт гүйцэтгэгч, эсхүл тэдгээрийн төлөөлөгч Нууцын зэрэглэлтэй мэдээллийг зөвшөөрөлгүйгээр задруулсан, урвуулан ашигласнаас үүдэн гарах хариуцлагыг хүлээнэ.</p> <p>(в) ТӨК нь Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж байгаагийн хувьд Нууцын зэрэглэлтэй мэдээлэл болон өөрийн үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай бусад мэдээллийг Монгол Улсын Засгийн газарт мэдээлж (задруулж) болохыг Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид хүлээн зөвшөөрч байна.</p> | <p>Directors, each Shareholder shall procure that its appointed Directors and officers, employees, contractors or agents sign undertakings with respect to Proprietary Information. Each Shareholder shall be responsible for the misuse or unauthorised disclosure of Proprietary Information by its appointed Directors, or any of the Shareholder's officers, employees, contractors or agents.</p> <p>(c) The Ivanhoe Shareholders acknowledge that as SHC is representing the Mongolian Government, it may disclose to the Mongolian Government the Proprietary Information and such other information that is necessary to perform its obligations.</p> |
| <p>17. ТӨК-ийн амлалт</p> <p>Дараахь хэлцлүүдийн аль нэг хэлцлийн үр дүнд Компанийн энгийн, эсхүл давуу эрхийн хувьцаа эзэмшигч болсон, эсхүл байж болох Айвенхоу групп, эсхүл Рио Тинтод группын Хамаарал бүхий аливаа компанид төлөх ёстой Төрөөс ногдуулсан татварыг ТӨК нь Хөрөнгө оруулалтын гэрээний 2.27-д заасны дагуу төлнө. Үүнд:</p> <p>(a) Компани Төрийн эзэмшлийн хувьцааг ТӨК-д шилжүүлэх, эсхүл олгох;</p> <p>(б) Энэхүү Гэрээний 10-т заасны дагуу ТӨК-ийн Компанид оруулах хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд ТӨК-д хийсэн санхүүжилт, эсхүл олгосон зээл (эсхүл түүнтэй төстэй зохицуулалт), түүний дотор үндсэн зээл, зээлийн хүүгийн төлбөр, түүнчлэн тэмдэгтийн хураамж, хэлцлийн татвар;</p> <p>(в) Энэхүү Гэрээний 12-т заасны дагуу ТӨК-ийн Компанид оруулах</p> | <p>17. Covenants of SHC</p> <p>In accordance with Clause 2.27 of the Investment Agreement, SHC shall pay any taxes imposed by the State upon or payable by the Company or by any Related Corporation of either the Ivanhoe Group or the Rio Tinto Group that may be or become a holder of either common or preferred shares of the Company as may result from any of the following transactions:</p> <p>(a) the transfer or issue of the Government Issue Shares by the Company to SHC;</p> <p>(b) the provision of funds or loans to SHC under clause 10 of this Agreement (or any similar arrangements), to fund SHC's investment in the Company, including all repayments of principal and interest, including stamp duties and transaction taxes;</p> <p>(c) the provision of funds or loans by a member of the Ivanhoe Group or a member of the Rio Tinto Group to the Company on behalf of or attributable to SHC, under clause 12 of this Agreement (or any similar arrangements), in order to fund investment by SHC in the Company,</p> |

| | |
|--|---|
| <p>хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхийн тулд Айвенхоу группын, эсхүл Рио Тинто группын аль нэг гишүүн ТӨК-ийн нэрийн өмнөөс буюу түүнд хамааралтайгаар хийсэн санхүүжилт, эсхүл олгосон зээл (эсхүл түүнтэй төстэй зохицуулалт), түүний дотор үндсэн зээл, зээлийн хүүгийн төлбөр;</p> <p>(г) энэхүү Гэрээний 19-д заасан Компанийн аливаа тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээний 15.7.8-д заасны дагуу Компанид тусгай зөвшөөрөл, эсхүл эрхийг шилжүүлэх;</p> <p>(д) ТӨК (эсхүл түүнийг залгамжлагч)-ийн эзэмшиж буй Хувьцаанд Компаниас тухай бүрт төлсөн Ногдол ашиг.</p> | <p>including all repayments of principal and interest;</p> <p>(d) the transfer of any tenement of the Company referred to in clause 19, or the transfer of licences or rights to the Company in accordance with Clause 15.7.8 of the Investment Agreement; and</p> <p>(e) dividends paid by the Company in respect of the Shares held by SHC from time to time (or any successor).</p> |
| <p>18. Гэрээний үйлчлэл</p> <hr/> <p>18.1 Хувь нийлүүлэгчдийн гэрээ нь Компанийн дүрмээс давуу байх</p> <p>Хэрэв энэхүү Гэрээний заалт нь Компанийн дүрмийн заалттай зөрчилдөж байвал тухайн зөрчилтэй асуудлын хувьд энэхүү Гэрээний заалтыг баримтална.</p> <p>18.2 Гэрээний заалтыг Компанийн дүрмийн заалтад тооцох</p> <p>Энэхүү Гэрээний заалтыг түүний нөхцөлийн дагуу хүчин төгөлдөр байлгах зорилгоор Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинэ заалт оруулах шаардлагатай бол энэхүү Гэрээний холбогдох заалтыг Компанийн дүрмийн нэг хэсэг гэж тооцох бөгөөд шаардлагатай тохиолдолд Хувь нийлүүлэгчид Компанийн дүрэмд оруулах шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг дэмжсэн саналаар батална.</p> | <p>18. Operation of Agreement</p> <hr/> <p>18.1 Shareholders' Agreement to override Charter</p> <p>If there is any inconsistency between the provisions of this Agreement and the provisions of the Company's Charter, then the provisions of this Agreement prevail to the extent of the inconsistency.</p> <p>18.2 Agreement provision deemed to be in Charter</p> <p>If it is necessary to amend or include a provision in the Charter to ensure that a provision of this Agreement is effective in accordance with its terms, then the relevant provision of this Agreement shall be deemed to form part of the Charter and, if required, the Shareholders shall approve by affirmative vote the necessary amendments to be made to the Charter.</p> |
| <p>19. Оюу толгой төсөлд хамааралгүй тусгай зөвшөөрлийг шилжүүлэх</p> <hr/> <p>(a) Компани нь эзэмшиж буй тусгай зөвшөөрлүүдээ шилжүүлэх бөгөөд Оюу толгой төсөлд хамаарах бүх тусгай зөвшөөрөл</p> | <p>19. Transfer of non-OT Project tenements</p> <hr/> <p>(a) The tenement holding of the Company will be transferred (to the extent this has not already been done prior to the date of this Agreement) such</p> |

| | |
|---|---|
| <p>(энэхүү Гэрээ байгуулахаас өмнө шилжүүлээгүй)-өө хадгалж, эзэмшинэ. Ийнхүү бүтцийн өөрчлөлт хийсний дараа Компани нь:</p> <p>(i) 6709A тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл;</p> <p>(ii) 6708A, 6710A тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл;</p> <p>(iii) 6709A тоот тусгай зөвшөөрлийн талбайтай зэрэгцээ, эсхүл түүний эргэн тойрны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас гэрээний дагуу ашиг хүртэх Компанийн эрхийг тус тус эзэмшинэ.</p> <p>(б) Компани нь Оюу толгой төсөлд хамааралгүй бусад бүх тусгай зөвшөөрөл, түрээс, зөвшөөрөл болон бусад эрх (болон тэдгээрт холбогдох хөрөнгө) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдийн сонгосон Монгол Улсын өөр этгээдэд шилжүүлнэ. Ингэснээр тухайн тусгай зөвшөөрөл, эрх, холбогдох хөрөнгийг эзэмших Компанийн эрх дуусгавар болно.</p> <p>(в) Энэхүү Гэрээний 19-д заасны дагуу хийх шилжүүлэг, хэлцлийг тэдгээр шилжүүлэг, хэлцлийг гүйцэтгэхэд шаардлагатай бүх зөвшөөрлийг Засгийн газраас өгснөөс хойш 45 (дөчин тав)-н Ажлын өдрийн дотор гүйцэтгэж дуусгана.</p> | <p>that all tenements retained and held by the Company will be those that are connected to the OT Project. Accordingly, following the restructure, the Company will hold the following:</p> <p>(i) mining license 6709A;</p> <p>(ii) mining licenses 6708A and 6710A; and</p> <p>(iii) the contractual rights of the Company to earn an interest in exploration and mining licenses adjacent to or surrounding mining license 6709A.</p> <p>(b) The Company intends to transfer all other licenses, leases, permits or other tenements and authorities (and related assets) that are not related to the OT Project to another Mongolian entity nominated by the Ivanhoe Shareholders. Accordingly, such tenements, rights and related assets will no longer be held by the Company.</p> <p>(c) The transfers and transactions under this clause 19 shall be completed within 45 Working Days of the receipt of all of the Government approvals and authorisations required for the completion of the transfers and transactions under this clause 19.</p> |
| <p>20. Харилцан хохиролгүй болгох</p> <p>(a) Энэхүү Гэрээгээр хүлээсэн материаллаг үүргээ зөрчсөн тохиолдолд тухайн зөрчил гаргасан Хувь нийлүүлэгч нь уг зөрчлийн улмаас бусад Хувь нийлүүлэгч болон Компанид учирсан шууд хохирол, алдагдал, түүний дотор бүх өртөг, зардал, хүү, хууль зүйн үйлчилгээний хөлс, шинжээчийн хөлс болон бусад төлбөрийг нөхөн төлөх замаар бусад Хувь нийлүүлэгч болон Компанийг хохиролгүй болгоно.</p> <p>(б) Нөхөн төлбөрийг хохирол учирсан, эсхүл алдагдал үүссэн өдрөөс хойш 60 (жар) хоногийн дотор төлнө. Нөхөн төлбөрийг</p> | <p>20. Mutual indemnity</p> <p>(a) In the event of a breach of a material obligation of this Agreement, the Shareholder in breach shall indemnify the other Shareholder(s) and the Company for the direct damages and loss suffered by the other Shareholder(s) and the Company, including all costs, expenses, interest and legal fees, experts' fees and other disbursements incurred.</p> <p>(b) Indemnification shall be paid within sixty (60) days of the date of occurrence of the damage or loss. The indemnification shall be paid in USD.</p> |

| | |
|---|--|
| ам.доллараар төлнө. | |
| <p>21. Гэрээний үргэлжлэх хугацаа болон Гэрээ дуусгавар болох</p> <p>21.1 Өмнөх Хувь нийлүүлэгчдэд Гэрээ үйлчлэхгүй байх</p> <p>Энэхүү Гэрээгээр зөвшөөрөгдсөний дагуу энэхүү Гэрээний 21.3-д заасныг баримтлан бүх Хувьцаагаа шилжүүлсэн Хувь нийлүүлэгчид энэхүү Гэрээ үйлчлэхгүй.</p> <p>21.2 Гэрээний хугацаа</p> <p>Энэхүү Гэрээ нь Компанийг татан буулгахаар шийдвэрлэх хүртэл, эсхүл Талууд энэхүү Гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгохоор бичгээр харилцан тохиролцох хүртэл бүхэлдээ хүчинтэй байж үйлчилнэ.</p> <p>21.3 Гэрээ дуусгавар болох нь тодорхой заалтад нөлөөлөхгүй байх</p> <p>Аливаа шалтгааны улмаас энэхүү Гэрээ дуусгавар болох болон аливаа Хувь нийлүүлэгч аливаа Хувьцаа эзэмших эрхгүй болох нь:</p> <p>(a) Гэрээ дуусгавар болох, эсхүл түүнийг хүчингүй болгохоос өмнө бий болсон Талуудын бүрэн биелүүлээгүй аливаа үүргийг үл хөндөнө;</p> <p>(б) Гэрээ дуусгавар болсноор, эсхүл түүнийг хүчингүй болгосноор хүчин төгөлдөр болохоор болон түүнээс хойш хүчинтэй хэвээр үлдэхээр энэхүү Гэрээнд заасан түүний аливаа заалтад нөлөөлөхгүй.</p> <p>22. Маргаан шийдвэрлэх</p> | <p>21. Duration and termination</p> <p>21.1 Former Shareholder not bound</p> <p>Subject to clause 21.3, this Agreement ceases to apply to a Shareholder which has transferred all of its Shares as permitted by this Agreement.</p> <p>21.2 Term</p> <p>This Agreement continues in full force and effect until the conclusion of the liquidation of the Company or its earlier termination by written agreement between the Parties.</p> <p>21.3 Termination not to affect certain provisions</p> <p>The termination of this Agreement however caused and the ceasing by any Shareholder to hold any Shares:</p> <p>(a) will be without prejudice to any obligation of the Parties which has accrued prior to that termination or cessation and which remains unsatisfied; and</p> <p>(b) will not affect any provision of this Agreement which is expressed to come into effect on, or to continue in effect after, that termination or cessation.</p> |
| <p>22.1 Маргааныг хэлэлцэн шийдвэрлэх</p> <p>Энэхүү Гэрээнээс үүдэлтэй буюу түүнтэй холбоотойгоор Талуудын хооронд аливаа маргаан гарвал түүнийг эхний ээлжинд сайн санааны үндсэн дээр хэлэлцээ хийх замаар шийдвэрлэх бөгөөд аль нэг тал нь</p> | <p>22. Dispute resolution</p> <p>22.1 Negotiation of dispute</p> <p>Any disputes between the Parties arising out of or in connection with this Agreement shall be settled by the Parties first attempting in good faith to negotiate a resolution and if a negotiated resolution to the dispute is not agreed to within 60 (sixty) Working Days of the date of a Party's request in writing for</p> |

хэлэлцээ хийх хүсэлтийг бичгээр тавьснаас хойш 60 (жар)-н Ажлын өдөр, эсхүл өөрөөр тохиролцсон хугацааны дотор Талууд нэгдсэн шийдвэрт хүрч чадаагүй бол уг маргааныг энэхүү Гэрээний 22.2-т заасны дагуу шийдвэрлэнэ.

22.2 Арбитр

Энэхүү Гэрээний 22.1-д заасны дагуу маргааныг хэлэлцээний журмаар шийдвэрлэж чадаагүй бол түүнийг уг маргаан гарсан өдөр үйлчилж буй Нэгдсэн Үндэстний Байгууллагын Олон улсын худалдааны эрх зүйн комиссын Арбитрын Дүрэм /НҮБОУХЭЗК Дүрэм/-ийн дагуу заавал биелүүлэх арбитрын зарчмаар шийдвэрлэнэ. Арбитрын үйл ажиллагаа дараахь журмаар явагдана.

- (a) арбитрчийн тоо 3 (гурав) байх;
- (b) 3 (гурав)-н арбитрчийг НҮБОУХЭЗК-ийн Дүрмийн 7 болон 8-д заасан журмын дагуу томилох;
- (v) арбитрын ажиллагааг Англи хэл дээр явуулах;
- (г) арбитрын бүрэлдэхүүн Хувь нийлүүлэгчдийн гэрээг тайлбарлахдаа Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг хэрэглэх;
- (д) арбитрын ажиллагааг явуулах газар нь Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хот байх;
- (e) арбитрын ажиллагааг НҮБОУХЭЗК-ийн дүрмийн дагуу Лондонгийн Олон улсын арбитрын Шүүх удирдан явуулах.

22.3 Арбитрын шийдвэрийг гүйцэтгэх болон хэрэгжүүлэх

Арбитрын шийдвэр нь эцсийнх байх бөгөөд уг шийдвэрийг Талууд заавал биелүүлнэ. Арбитрын шийдвэрийг түүнийг гүйцэтгэх эрх бүхий аливаа шүүхэд гүйцэтгүүлэхээр хүргүүлж болох бөгөөд ингэхдээ хамгийн түрүүнд Монгол Улсын зохих шүүхэд хүргүүлнэ. Хэрэв Монгол Улсын зохих шүүхэд хүргүүлсэн шийдвэрийг хүргүүлснээс хойш 30 (гуч) хоногийн дотор гүйцэтгээгүй бол эрх бүхий аливаа бусад шүүхэд хүргүүлж болно. Талууд арбитрын шийдвэрийг хүлээн авч биелүүлэх үүрэгтэйгээ хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд тухайн шийдвэрийг биелүүлэхээс аливаа хэлбэрээр зайлсхийхгүй байна.

such negotiation, or such other time period as may be agreed, then the dispute shall be settled in accordance with clause 22.2.

22.2 Arbitration

If a dispute is not settled by negotiation in accordance with clause 22.1, it shall be resolved by binding arbitration in accordance with the procedures under the Arbitration Rules of the United Nations Commission on International Trade Law (the *UNCITRAL Rules*) as in force at the time of the dispute.

Accordingly, the following shall apply:

- (a) the number of arbitrators shall be 3 (three);
- (b) the 3 (three) arbitrators shall be appointed in accordance with rules 7 and 8 of the UNCITRAL Rules;
- (c) the language of the arbitration shall be English;
- (d) the arbitrators shall apply the laws and regulations of Mongolia to the interpretation of this Agreement;
- (e) the place of arbitration shall be in London, United Kingdom; and
- (f) the arbitral proceedings shall be administered under the UNCITRAL Rules by the London Court of International Arbitration.

22.3 Execution and enforcement of arbitral award

The arbitral award shall be final and binding on the Parties, and judgment on the award may be entered by any court having competent jurisdiction, provided that an arbitral award shall first be presented in an appropriate court of Mongolia for execution and enforcement. If such execution and enforcement has not occurred within 30 (thirty) days of presentation, the award may be presented in any other court having competent jurisdiction. The Parties hereby commit to fulfil the execution and enforcement of the arbitral award and shall not raise any defence to its execution and enforcement.

| | |
|---|---|
| <p>22.4 Заалт хүчинтэй хэвээр үлдэх</p> <p>Энэхүү Гэрээний 22-д заасан маргаан шийдвэрлэх журам нь энэхүү Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд болон Гэрээ түүний хугацаа дууссаны дараа, эсхүл хугацаанаас нь өмнө дуусгавар болгосны дараа энэхүү Гэрээтэй холбоотой, эсхүл түүнээс үүдсэн үйл ажиллагааны талаар Талуудын хоорондын гарсан аливаа маргаанд нэгэн адил хамаарна.</p> | <p>22.4 Continued application of clause</p> <p>The provisions of this clause 22 shall continue to apply to any dispute that arises during the term of this Agreement or any dispute that occurs after the expiry or earlier termination of this Agreement in regard to activities arising out of or in connection with this Agreement.</p> |
| <p>23. Бусад заалт</p> <hr/> <p>23.1 Мэдэгдэл</p> <p>Энэхүү Гэрээний дагуу хүргүүлэх, эсхүл хийх аливаа мэдэгдэл, шаардлага, зөвшөөрөл, бусад харилцаа холбоо (цаашид “Мэдэгдэл” гэх)-г :</p> <p>(a) бичгээр үйлдэж, илгээгчийн эрх олгосон этгээд гарын үсэг зурсан байна;</p> <p>(б) Монгол Улсын нутаг дэвсгэрийн дотор хүргэх Мэдэгдлийн хувьд тухайн мэдэгдлийг хүлээн авах ёстой этгээдэд биечлэн хүргэнэ. Хэрэв Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна хүргэх Мэдэгдлийн хувьд тухайн мэдэгдлийг биечлэн, эсхүл хүлээн зөвшөөрөгдсөн буухиа шуудангийн үйлчилгээгээр дор дурдсан хаягаар, эсхүл хүлээн авах ёстой этгээдээс илгээгчид хамгийн сүүлд мэдэгдсэн хаягаар тус тус хүргэнэ:</p> <p>(i) ТӨК-д: Монгол Улс Улаанбаатар-211238 Чингэлтэй дүүрэг 5 дугаар хороо Дипломат 95/37 Эрдэнэс МГЛ ХХК Хэнд: Гүйцэтгэх захиралд</p> | <p>23. Miscellaneous</p> <hr/> <p>23.1 Notices</p> <p>Any notice, demand, consent or other communication (a <i>Notice</i>) given or made under this Agreement:</p> <p>(a) must be in writing and signed by a person duly authorised by the sender;</p> <p>(b) for Notices delivered within Mongolia, must be delivered to the intended recipient by hand, and for Notices delivered outside Mongolia, must be delivered by hand or by any recognized express courier service, to the address below or the address last notified by the intended recipient to the sender:</p> <p>(i) to SHC:</p> <p>Erdenes MGL (SHC) Limited Unit 37, Diplomat BLDG. 95 5 khoroo, Chingiltei District Ulaanbaatar-211238, Mongolia</p> <p>Attention: Executive Director Fax No: +976 701 10725</p> <p>(ii) to the Ivanhoe Shareholders:</p> |

Факсын дугаар: +976 70110725

(ii) Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид:
АйВиЭн-д:
Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лимитед
9 Колумбус Центр Билдинг
Роуд Таун
Тортола
Британийн Виржинийн Арлууд
Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад

ОТН-д:
Оюу Толгой Нидерланд Би.Ви
200 Примс Бернхардплайн
1097 ЖиБи
Амстердам
Нидерланд Улс
Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад
АйВиЭн болон ОТН-д (аль холбогдох нь)
(мэдэгдэлд тооцохгүй):

Айвенхоу Майнз Монголия Инк ХХК-д
Монгол Улс
Улаанбаатар 210349
Залуучуудын өргөн чөлөө-26
Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо
Сөүл бизнесийн төв
Хэнд: Ерөнхий захиралд

хувийг (мэдэгдэлд тооцохгүй):
Айвенхоу Майнз Лтд
999 Канад Плэйс
654 тоот
Ванкувер хот
Британийн Колумби Ви6Си 3И1
Канад Улс
Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад

to IVN:
Ivanhoe Oyu Tolgoi (BVI) Limited
9 Columbus Centre Building
Road Town
Tortola
British Virgin Islands
Attention: Corporate Secretary

to OTN:
Oyu Tolgoi Netherlands B.V.
Prims Bernhardplein 200
1097 JB
Amsterdam
The Netherlands
Attention: Corporate Secretary

with a copy to IVN / OTN (as applicable) (which shall not constitute notice):
c/o Ivanhoe Mines Mongolia Inc LLC
Seoul Business Center
1st khroo Bayanzurkh District
Zalluuchuud Avenue-26
Ulaanbaatar 210349
MONGOLIA
Attention: Managing Director

with a copy to (which shall not constitute notice):
Ivanhoe Mines Ltd
999 Canada Place
Suite 654
Vancouver
British Columbia V6C3E1
Canada
Attention: Corporate Secretary

| | |
|--|---|
| <p>Факсын дугаар: +1 604-682-2060</p> <p>хувийг (мэдэгдэлд тооцохгүй): Рио Тинто Интернейшнл Холдингс Лимитед 2 Ийстборн террас Паддингтон Лондон Ви26ЭлЖи Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс Хэнд: Компанийн нарийн бичгийн даргад Факс: +44 20 7781 1800</p> <p>(iii) Компанид: Айвенхоу Майнз Монголия Инк ХХК Монгол Улс Улаанбаатар 210349 Залуучуудын өргөн чөлөө-26 Баянзүрх дүүрэг, 1 дүгээр хороо Сөүл бизнесийн төв Хэнд: Ерөнхий захиралд Факсын дугаар: +976 1133 1890</p> <p>(в) дараахь нөхцөлд зохих ёсоор хүргүүлсэн, эсхүл хүлээлгэн өгсөнд тооцно:</p> <p>(i) биечлэн хүргэж өгч буй бол гардуулсан мөчөөс;</p> <p>(ii) хүлээн зөвшөөрөгдсөн буухиа шуудангийн үйлчилгээг ашигласан тохиолдолд (тухайн улс доторх хаягаар илгээж буй бол) илгээснээс хойш 2 (хоёр) Ажлын өдрийн дараа, эсхүл (өөр улс дахь хаягаар илгээж буй бол) илгээснээс хойш 7 (долоо)-н Ажлын өдрийн дараа;</p> <p>тус тус хүргэгдсэнд тооцно.</p> <p>хэрэв Мэдэгдлийг зохих ёсоор хүргүүлсэн, эсхүл хүлээлгэн өгсөн өдөр нь тухайн мэдэгдлийг илгээсэн газрын Ажлын өдөр биш байсан бол, эсхүл 16.00 цагаас (тухайн орон нутгийн) хойш хүргүүлсэн бол тухайн газрын дараагийн Ажлын өдөр ажлын цаг эхлэхэд зохих ёсоор хүргүүлсэн, эсхүл</p> | <p>Fax No: +1 604-682-2060</p> <p>and</p> <p><i>with a copy to (which shall not constitute notice):</i> Rio Tinto International Holdings Limited: 2 Eastbourne Terrace Paddington London W26LG United Kingdom Attention: Company Secretary Fax No: +44 20 7781 1800</p> <p>(iii) to the Company:</p> <p>Ivanhoe Mines Mongolia Inc LLC Seoul Business Center 1st khroo Bayanzurkh District Zalluuchuud Avenue-26 Ulaanbaatar 210349 MONGOLIA Attention: Managing Director Fax No: +976 1133 1890</p> <p>(c) will be taken to be duly given or made:</p> <p>(i) in the case of delivery in by hand, when delivered; and</p> <p>(ii) in the case of delivery by recognized express courier service, two Working Days after the date of despatch (if despatched to an address in the same country) or seven Working Days after the date of despatch (where despatch to an address in another country),</p> <p>but if the result is that a Notice would be taken to be given or made on a day that is not a Working Day in the place to which the Notice is sent</p> |
|--|---|

| | |
|---|---|
| <p>хүлээлгэн өгсөнд тооцно.</p> | <p>or is later than 4pm (local time) it will be taken to have been duly given or made at the start of business on the next Working Day in that place;</p> |
| <p>(г) Англи, Монгол хэлээр үйлдэнэ.</p> | <p>and</p> |
| <p>23.2 Иргэний хуулийг хэрэглэх</p> | <p>(d) must be in English and Mongolian.</p> |
| <p>Иргэний хуулийн 5.1, 5.2 болон 5.3 дахь заалтууд энэхүү Гэрээнд үйлчилнэ.</p> | <p>23.2 Civil Code application</p> |
| <p>23.3 Хууль биелүүлэх</p> | <p>Articles 5.1, 5.2 and 5.3 of the Civil Code apply to this Agreement.</p> |
| <p>Хувь нийлүүлэгч болон түүний Хамаарал бүхий компани (аль холбогдох нь) нь авилгатай тэмцэх талаархи өөрийн үүсгэн байгуулагдсан улсын болон Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх бөгөөд Монгол Улсад явуулах үйл ажиллагаагаа эдгээр хуулийн хүрээнд явуулна.</p> | <p>23.3 Compliance with laws</p> <p>Each Shareholder and its Related Corporations are subject to the anti-bribery/corruption laws of the jurisdictions in which the Shareholder or its Related Corporations (as applicable) are organized, including Mongolia, and the Shareholder and its Related Corporations shall conduct their activities in Mongolia in accordance with their obligations under such laws.</p> |
| <p>23.4 Нэмэлт баталгаа</p> | <p>23.4 Further assurances</p> |
| <p>Талууд энэхүү Гэрээний заалтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай, эсхүл тохиромжтой бүх баримт бичгийг үйлдэн эмхэтгэж, хүргүүлэх талаар хамтарч ажиллана.</p> | <p>The Parties shall co-operate in compiling and delivering all documents necessary or convenient to carry out the provisions of this Agreement.</p> |
| <p>23.5 Гэрээний нэгдмэл байдал</p> | <p>23.5 Entire agreement</p> |
| <p>Энэхүү Гэрээний заалтууд нь үүгээр зохицуулж буй асуудлаар Талуудын хүрсэн бүхий л тохиролцоог хамарч байгаа болно.</p> | <p>The provisions of this Agreement contain the entire agreement between the Parties with respect to the subject matter of this Agreement.</p> |
| <p>23.6 Нэмэлт, өөрчлөлт</p> | <p>23.6 Amendment</p> |
| <p>Талууд зөвхөн өөр гэрээ байгуулах замаар энэхүү Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.</p> | <p>This Agreement may be amended only by another agreement executed by all the Parties.</p> |
| <p>23.7 Үйлчлэх хууль</p> | <p>23.7 Governing law</p> |
| <p>Энэхүү Гэрээг Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээний дагуу зохицуулж тайлбарлана.</p> | <p>This Agreement shall be governed by and interpreted in accordance with the laws of Mongolia and the international treaties to which Mongolia is a party.</p> |

| | |
|--|---|
| <p>23.8 Хэл</p> <p>Энэхүү Гэрээг монгол, англи хэлээр тус бүр 6 (зургаа)-н эх хувь үйлдэх бөгөөд Талууд хэл тус бүр дээрх нэг хувийг хадгална. Монгол, англи хэл дээрхи эх бичвэрүүд адил хүчинтэй байх бөгөөд харин хоёр хэл дээрхи бичвэрүүдийн хооронд зөрүү гарвал англи эх бичвэрийг баримталж байхаар Талууд харилцан тохиролцов.</p> <p>23.9 Компанийн нэр</p> <p>Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсны дараа Компанийн нэрийг “Оюу Толгой” ХХК гэж өөрчилж болохыг Талууд хүлээн зөвшөөрөв.</p> | <p>23.8 Language</p> <p>This Agreement will be provided in the Mongolian and English languages each in six (6) original copies, with each Party retaining one copy in each language. The Parties agree that the Mongolian and English language versions will be treated equally except that, in the event of any discrepancies between the two language versions, the English version shall prevail.</p> <p>23.9 Name of Company</p> <p>The Parties agree that after the date of this Agreement they may change the name of the Company to “Oyu Tolgoi LLC”.</p> |
| <p>24. Нэр томъёоны тодорхойлолт</p> <p>“Үндсэн хөрөнгийн зардал” гэж Оюу толгой төсөл болон Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу үндсэн хөрөнгийн зардал гэж тооцогддог бүх өртөг, зардал, төлбөрийг хэлнэ.</p> <p>“Санхүүжилтийн хүүгийн хувь” гэж энэхүү Гэрээний 10.3(г)(i)-д тодорхойлсон санхүүжилтийн хүүгийн хувийг хэлнэ.</p> <p>“Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр” гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.</p> <p>“Гүйцэтгэлийн өдөр” гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойшхи 21 (хорин нэг) дэх Ажлын өдөр, эсхүл Талуудын харилцан тохиролцсон Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойшхи өөр өдрийг хэлнэ.</p> <p>“Гэрээт талбай” гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.</p> <p>“Хяналт” гэж аж ахуйн нэгжийн хувьд, тухайн аж ахуйн нэгжийн Хувь нийлүүлэгчдийн хурал дээр тоологдож болох саналын олонхийг шууд буюу шууд бусаар эдлэх эрхтэй, эсхүл тухайн аж ахуйн нэгжийн захирлуудын олонхийг</p> | <p>24. Definitions</p> <p>Capital Costs means all costs, expenses and charges that are recognised as capital costs in accordance with internationally generally accepted accounting principles in relation to the OT Project and Core Operations.</p> <p>Carry Rate means the carry rate defined in clause 10.3(d)(i).</p> <p>Commencement of Production has the meaning given to that term in Chapter 16 of the Investment Agreement.</p> <p>Completion Date means the date which is 21 Working Days after the Effective Date, or such other date after the Effective Date as may be agreed between the Parties.</p> <p>Contract Area has the meaning given to that term in Chapter 16 of the Investment Agreement.</p> <p>Control means, with respect to a body corporate, the right to, directly or indirectly, exercise a majority of the votes which may be cast at a general meeting of the shareholders of the body corporate or the right to elect or appoint, directly or indirectly,</p> |

| | |
|---|---|
| <p>шууд буюу шууд бусаар сонгох, эсхүл томилох эрхтэй байхыг хэлэх бөгөөд Хяналтыг нэр үгээр хэрэглэвэл түүнийг эзэмшигч нь өмнө дурдсан эрхээ эдлэх бололцоо олгож буй аливаа ашиг сонирхол гэсэн утгыг илэрхийлнэ. (Хяналтад байгаа гэж өмнөх утгатай холбогдуулан ойлгохыг хэлнэ).</p> <p>“Үндсэн үйл ажиллагаа” гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.</p> <p>“ТУЗ-ийн гишүүн” гэж Компанийн дүрэм болон энэхүү Гэрээний 4.3-т заасны дагуу Компанийн ТУЗ-ийн гишүүний албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон хүнийг хэлнэ.</p> <p>“Захиран зарцуулах хувьцаа” гэж энэхүү Гэрээний 15.2(б)-д тодорхойлсон захиран зарцуулах хувьцааг хэлнэ.</p> <p>“Захиран зарцуулах” гэж аливаа хөрөнгийн хувьд, түүнийг худалдах, шилжүүлэх, эрх шилжүүлэх, Барьцаалах, тухайн хөрөнгийн эзэмшигч болохоо зарлах, эсхүл түүний үр ашгаас татгалзах, эсхүл бусад байдлаар тухайн хөрөнгийг (эсхүл тухайн хөрөнгө дэх аливаа сонирхол буюу тухайн хөрөнгийн аливаа хэсэг) захиран зарцуулах, эсхүл ийнхүү оролдохыг хэлнэ.</p> <p>“Ногдол ашиг” гэж Компани татвар төлсний дараахь Компанийн үйл ажиллагааны ашгаас Хувьцаанд хамааруулан төлөхөөр ТУЗ-өөс тогтоосон аливаа мөнгөн болон мөнгөн бус хуваарилалт (гэхдээ үүнд давуу эрхийн хувьцаа (Санхүүжүүлэх хувьцааг оролцуулан)-д төлөх ногдол ашиг хамаарахгүй)-ыг хэлнэ.</p> <p>“Хүчин төгөлдөр болох өдөр” гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.</p> <p>“Хувь нийлүүлэгчийн одоогийн зээл” гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр хүртэлх хугацаанд Оюу толгой төсөл болон Үндсэн үйл ажиллагаатай холбогдуулан Айвенхоу групп, эсхүл Рио Тинто группээс Компанид урьдчилан олгосон бүх санхүүжилт (дүнг Хөрөнгө оруулалтын гэрээний 15.7.5 дахь заалтын дагуу тодорхойлно) (тухайн санхүүжилтийг олгосон нөхцөл болон түүнийг Компани Үйл ажиллагааны зардал, эсхүл Үндсэн хөрөнгийн зардалд зарцуулсан эсэхээс үл хамааран)-ийг хэлэх бөгөөд үүнд санхүүжилтийн дүнд 9,9 хувиар</p> | <p>a majority of the directors of the body corporate and Control used as a noun means an interest of any kind which gives the holder the ability to exercise any of the foregoing powers (and Controlled has a corresponding meaning).</p> <p>Core Operations has the meaning given to that term in Chapter 16 of the Investment Agreement.</p> <p>Director means a person appointed or elected to the office of director of the Company in accordance with the Charter and in accordance with clause 4.3.</p> <p>Disposal Shares means the disposal shares defined in clause 15.2(b).</p> <p>Dispose in relation to any property means to sell, transfer, assign, create a Pledge over, declare oneself a trustee of or part with the benefit of or otherwise dispose of that property (or any interest in it or any part of it) or to attempt to do so.</p> <p>Dividend includes a cash or non-cash distribution that is declared payable by the Board of Directors in respect to Shares out of the operating profit after tax of the Company (but does not include a dividend on preferred shares (including Funding Shares)).</p> <p>Effective Date has the meaning given to that term in Chapter 16 of the Investment Agreement.</p> <p>Existing Shareholder Loans means all funds advanced to the Company up to the Effective Date (the quantum having been determined in accordance with Clause 15.7.5 of the Investment Agreement) by the Ivanhoe Group or the Rio Tinto Group in relation to the OT Project and Core Operations (irrespective of the terms on which those funds were advanced and whether expended by the Company as Operational Costs or Capital Costs), including interest on such amounts at the rate of 9.9% adjusted, on a quarterly basis, by the percentage of the variation in the US CPI over the preceding quarter.</p> |
|---|---|

| | |
|--|--|
| <p>тооцсон хүү багтана. Чингэхдээ энэ хүү нь АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийн өмнөх улирлын хэлбэлзлийн хувиар улирал тутам тогтоодог хувиудын нийлбэрээр тодорхойлогдоно.</p> <p>“Санхүүгийн жил” гэж 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацааг хэлнэ.</p> <p>“Санхүүжүүлсэн дүн” гэж энэхүү Гэрээний 10.1(б)-д тодорхойлсон санхүүжүүлсэн дүнг хэлнэ.</p> <p>“Санхүүжилтийн хугацаа” гэж Гүйцэтгэлийн өдрөөс эхлэн Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 3 (гурав)-н жил өнгөрөх хүртэлх хугацааг хэлнэ.</p> <p>“Санхүүжүүлэх хувьцаа” гэж Компанийн үндсэн хөрөнгөд давуу эрх эдлэх хувьцааг хэлэх бөгөөд үүнийг энэхүү Гэрээний 11-д илүү нарийвчлан тодорхойлсон.</p> <p>“Төрийн эзэмшлийн хувьцаа” гэж Гүйцэтгэлийн өдөр Компаниас гаргаж, ТӨК-д олгосон Хувьцааны тоог хэлэх бөгөөд ийнхүү олгосны дараа Компанийн Хувьцааны 34 (гучин дөрөв)-н хувийг ТӨК эзэмшинэ.</p> <p>“Хөрөнгө оруулалтын гэрээ” гэж Ашигт малтмалын тухай Монгол Улсын хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу Монгол Улсын Засгийн газар, Компани, Айвенхоу Майнз Лтд болон Рио Тинто Интернэшнл Холдингс Лимитедийн хооронд энэхүү Гэрээг байгуулсан, эсхүл байгуулах үед Оюу толгой төсөлтэй холбоотойгоор байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээг хэлнэ.</p> <p>“Айвенхоу групп” гэж Айвенхоу Майнз Лтд (Канад Улсын Юкон мужид үүсгэн байгуулагдсан) болон түүний Хяналтад байгаа аливаа этгээдийг хэлнэ.</p> <p>“Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид” гэж АйВиЭн болон ОТН-ийг хэлнэ.</p> <p>“АйВиЭн-ийн санхүүжүүлэгч” гэж АйВиЭн, ОТН, эсхүл тэдгээрийн санал болгосон АйВиЭн, ОТН-ийн Хамаарал бүхий компани зэрэг бусад төлөөлөгчийг хэлнэ.</p> <p>“Менежментийн үйлчилгээний төлбөр” гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16</p> | <p>Financial Year means 1 January to 31 December.</p> <p>Funded Amount means the funded amount defined in clause 10.1(b).</p> <p>Funding Period means the period commencing on the Completion Date and ending three years after the Commencement of Production.</p> <p>Funding Share means a preferred share in the capital of the Company, as further described in clause 11.</p> <p>Government Issue Shares means the number of Shares issued by the Company to SHC as at the Completion Date which will, after such issue, result in SHC holding 34% of the Shares in the Company.</p> <p>Investment Agreement means the Investment Agreement dated on or about the date of this Agreement, in relation to the OT Project, entered into between the Government of Mongolia, the Company, Ivanhoe Mines Ltd and Rio Tinto International Holdings Limited pursuant to Article 29 of the Minerals Law of Mongolia.</p> <p>Ivanhoe Group means Ivanhoe Mines Ltd (incorporated in Yukon, Canada) and any entity Controlled by Ivanhoe Mines Ltd.</p> <p>Ivanhoe Shareholders means IVN and OTN.</p> <p>IVN Provider means IVN, OTN or their nominated representative(s) including any Related Corporation of IVN or OTN.</p> |
|--|--|

| | |
|---|---|
| <p>дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна</p> <p>“Менежментийн баг” гэж энэхүү Гэрээний 6.2(а)-д тодорхойлсон менежментийн багийг хэлнэ.</p> <p>“Сонгогдсон гуравдагч этгээд” гэж энэхүү Гэрээний 15.2(в)(iii)-д тодорхойлсон сонгогдсон гуравдагч этгээдийг хэлнэ.</p> <p>“Мэдэгдэл” гэж энэхүү Гэрээний 23.1-д тодорхойлсон мэдэгдлийг хэлнэ.</p> <p>“Санал гаргах хугацаа” гэж энэхүү Гэрээний 15.2(г)-д тодорхойлсон хугацааг хэлнэ.</p> <p>“Үйл ажиллагааны зардал” гэж Оюу толгой төсөл болон Үндсэн үйл ажиллагаатай холбоотойгоор Компани, эсхүл Менежментийн багийн, эсхүл тэдгээрийн өмнөөс гаргасан бүх өртөг, зардал, төлбөр (Үндсэн хөрөнгийн зардлаас бусад)-ийг хэлнэ.</p> <p>“Опцион эрх” гэж энэхүү Гэрээний 15.10(а)-д тодорхойлсон опцион эрхийг хэлнэ.</p> <p>“Опцион эрхийн хувьцаа” гэж энэхүү Гэрээний 15.10(а)-д тодорхойлсон опцион эрхийн хувьцааг хэлнэ.</p> <p>“Бусад Хувь нийлүүлэгч” гэж энэхүү Гэрээний 15.1-д тодорхойлсон бусад хувь нийлүүлэгчийг хэлнэ.</p> <p>“Оюу толгой төсөл” гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.</p> <p>“Үлдэгдэл төлбөр” гэж энэхүү Гэрээний 10.3(г)(ii)-д тодорхойлсон үлдэгдэл төлбөрийг хэлнэ.</p> <p>“Дийлэнх олонхи” гэж гуравны хоёр (2/3) эсхүл түүнээс дээш хувийг хэлнэ.</p> <p>“Тал” гэж ТӨК, АйВиЭн, ОТН, Компани болон энэхүү Гэрээ, эсхүл Хөрөнгө оруулалтын гэрээний дагуу зөвшөөрөгдсөн тэдгээрийн залгамжлагч болон</p> | <p>Management Services Payment has the meaning given to that term in Chapter 16 of the Investment Agreement.</p> <p>Management Team means the management team defined in clause 6.2(a).</p> <p>Nominated Third Party means the nominated third party defined in clause 15.2(c)(iii).</p> <p>Notice means the notice defined in clause 23.1.</p> <p>Offer Period means the offer period defined in clause 15.2(d).</p> <p>Operating Costs means all costs, expenses and charges incurred by or on behalf of the Management Team or the Company in relation to the OT Project and Core Operations (other than Capital Costs).</p> <p>Option means the option defined in clause 15.10(a).</p> <p>Option Shares means the option shares defined in clause 15.10(a).</p> <p>Other Shareholders means the other shareholders defined in clause 15.1.</p> <p>OT Project has the meaning given to that term in Chapter 16 of the Investment Agreement.</p> <p>Outstanding Balance means the outstanding balance defined in clause 10.3(d)(ii).</p> <p>Overwhelming Majority means two thirds (2/3) or more.</p> <p>Party means each of SHC, IVN, OTN, the Company and their successors and assigns as permitted in accordance with this Agreement or the Investment Agreement.</p> |
|---|---|

томилогдсон этгээд бүрийг хэлнэ.

“**Барьцаа**” гэж энэхүү Гэрээний 15.4-д тодорхойлсон барьцааг хэлнэ.

“**Эзэмшлийн хувь хэмжээ**” гэж Хувь нийлүүлэгчийн хувьд Компани дахь тухайн Хувь нийлүүлэгчийн шууд эзэмшдэг Хувьцаанд хамаарах Эзэмшлийн хувь хэмжээг хэлнэ (Төрийн эзэмшлийн хувьцааг гаргаж, ТӨК-д олгосны дараа ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээ нь 34 (гучин дөрөв)-н хувь байна).

“**Зөвшөөрөгдсөн барьцаа**” гэж энэхүү Гэрээний 15.5(б)-д тодорхойлсон зөвшөөрөгдсөн барьцааг хэлнэ.

“**Зөвшөөрөгдсөн барьцаалагч**” гэж энэхүү Гэрээний 15.5(б)(i)-д тодорхойлсон зөвшөөрөгдсөн барьцаалагчийг хэлнэ.

“**Нууцын зэрэглэлтэй мэдээлэл**” гэж бусад Талд өгсөн Хувь нийлүүлэгч, эсхүл түүний Хамаарал бүхий компани, Компани, эсхүл Менежментийн багийн мэдээлэл бөгөөд үүнд технологи, процесс, бүтээгдэхүүн, техникийн үзүүлэлтүүд, шинэ бүтээл, худалдааны нууц, ноу-хау болон бизнесийн чухал бусад мэдээлэл зэрэг нууц шинж чанартай, олон нийтэд ил болоогүй мэдээлэл хамаарна (гэхдээ эдгээрээр хязгаарлагдахгүй). .

“**АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексээр тохируулсан Санхүүжилтийн улирал тутмын хүү**” гэж өмнөх улирал дахь АНУ-ын Хэрэглээний үнийн индексийн хэлбэлзлийн хувиар улирал тутам тохируулдаг улирал тутмын хүүг хэлэх бөгөөд жилийн нийлбэр нь 9.9 хувь байна.

“**Хамаарал бүхий компани**” гэж:

- (a) Айвенхоу группийн аливаа гишүүний хувьд - Айвенхоу групп болон Рио Тинто группийн аливаа өөр гишүүн;
- (b) Рио Тинто группийн аливаа гишүүний хувьд - Рио Тинто группийн болон Айвенхоу группийн аливаа өөр гишүүн;
- (c) ТӨК-ийн хувьд - Төрийн 100 (нэг зуу) хувийн өмчлөлд болон түүний Хяналтад байгаа аливаа өөр компанийг тус тус хэлнэ.

Pledge means the pledge defined in clause 15.4.

Percentage Interest means, in relation to a Shareholder, that Shareholder's percentage interest of Shares it holds directly in the Company (and immediately after the issue of the Government Issue Shares to SHC, the Percentage Interest of SHC will be 34%).

Permitted Charge means the permitted charge defined in clause 15.5(b).

Permitted Chargee means the permitted chargee defined in clause 15.5(b)(i).

Proprietary Information means that information of a Shareholder or its Related Corporations, the Company or the Management Team which is disclosed to another Party, which is confidential in nature and not in the public domain, including, without limitation, information relating to technology, processes, products, specifications, inventions, trade secrets, know-how and other information of a commercially sensitive nature.

Quarterly US CPI Adjusted Carry Rate means the quarterly rate that results in an effective annual rate of 9.9% and which is then adjusted, on a quarterly basis, by the percentage of the variation in the US CPI over the preceding quarter.

Related Corporation means:

- (a) in relation to any member of the Ivanhoe Group – any other member of the Ivanhoe Group and any member of the Rio Tinto Group;
- (b) in relation to any member of the Rio Tinto Group – any other member of the Rio Tinto Group and any member of the Ivanhoe Group; and
- (c) in relation to SHC – any other corporation that is wholly-owned and Controlled solely by the State.

“**Хамааралтай хэлцэл**” гэж Компани /нэг талаас/ болон аливаа Хувь нийлүүлэгч, эсхүл аливаа Хувь нийлүүлэгчийн Хамаарал бүхий компани /нөгөө талаас/-ийн хооронд хийгдсэн гэрээний дагуу хийх нийт төлбөр нь нэг сая таван зуун мянган (1,5 сая) ам.доллараас хэтрэх аливаа хэлцэл (эргэлзээ төрүүлэхгүй байх үүднээс энэхүү Гэрээний 5.2-д заасан Хамааралтай хэлцлийн холбогдолтой заалтууд нь энэхүү Гэрээний 6.2(a)-д заасан Менежментийн багийг авч ажиллуулах гэрээнд хамаарахгүй)-ийг хэлнэ.

“**Тогтоол**” гэж Улсын Их Хурлын 2009 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 57 дугаар тогтоолыг хэлнэ.

“**Рио Тинто групп**” гэж Рио Тинто Пи Эл Си (Англид үүсгэн байгуулагдсан), Рио Тинто Лимитед (Австрали Улсад үүсгэн байгуулагдсан) болон Рио Тинто Пи Эл Си болон/эсхүл Рио Тинто Лимитедийн Хяналтад буй аливаа этгээдийг хэлнэ.

“**Хувьцаа**” гэж Компанийн хөрөнгө дэх энгийн хувьцааг хэлнэ.

“**Хувь нийлүүлэгч**” гэж ТӨК, АйВиЭн болон ОТН болон Хувьцаа эзэмшиж буй аливаа бусад Талыг хэлнэ.

“**Хувь нийлүүлэгчийн өр**” гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр, эсхүл түүнээс хойш Хувь нийлүүлэгчдээс, эсхүл тэдгээрийн нэрийн өмнөөс Компанид урьдчилан төлсөн нийт санхүүжилт, түүний дотор энэхүү Гэрээний 12-т заасны дагуу хийсэн санхүүжилтийн дүнгийн төлөгдөөгүй үлдэгдэл, түүнд тооцох хүүгийн нийлбэрийг хэлнэ.

“**ТӨК-аас Шаардсан мөнгөн хөрөнгө**” гэж Шаардсан мөнгөн хөрөнгө дэх ТӨК-ийн Эзэмшлийн хувь хэмжээг хэлнэ.

“**Төр**” гэж Монгол Улсыг хэлнэ.

“**Шилжүүлэх мэдэгдэл**” гэж энэхүү Гэрээний 15.2(в)-д тодорхойлсон шилжүүлэх мэдэгдэлийг хэлнэ.

“**Шилжүүлэх үнэ**” гэж энэхүү Гэрээний 15.2(в)(i)-д тодорхойлсон шилжүүлэх үнийг хэлнэ.

Relevant Transaction means any transaction between the Company (on the one hand) and any Shareholder or Related Corporation of any Shareholder (on the other hand) where the total consideration payable under the contract documenting the transaction exceeds one million five-hundred thousand USD (USD1.5 million) (and, for the avoidance of doubt, the Relevant Transaction provisions in clause 5.2 do not apply to a contract for the engagement of the Management Team as described in clause 6.2(a)).

Resolution means Resolution Number 57 of the State Great Khural dated 16 July 2009.

Rio Tinto Group means Rio Tinto plc (incorporated in England) and Rio Tinto Limited (incorporated in Australia), and any entity Controlled by Rio Tinto plc and/or Rio Tinto Limited.

Share means a common share in the capital of the Company.

Shareholder means each of SHC, IVN and OTN, and each other Party who holds Shares.

Shareholder Debt means, at any time, the aggregate principal amount outstanding at the time of all sums advanced to the Company by or on behalf of Shareholders on or after the Effective Date, including as contemplated by clause 12, and interest on such sums.

SHC Called Sum means SHC's Percentage Interest of a Called Sum.

State means Mongolia.

Transfer Notice means the transfer notice defined in clause 15.2(c).

Transfer Price means the transfer price defined in clause 15.2(c)(i).

“Шилжүүлэгч” гэж энэхүү Гэрээний дагуу Хувьцаагаа бүгдийг нь, эсхүл хэсгийг нь шилжүүлэхээр санал болгож буй Хувь нийлүүлэгчийг хэлэх бөгөөд энэ нь Хувьцааны тухайн шилжүүлгийн бүртгэлийн өмнөх болон дараахь үеийн Хувь нийлүүлэгчийг илэрхийлнэ.

“АНУ-ын Хэрэглээний Үнийн Индекс” гэж энэхүү Гэрээний 10.3(в)(iii)-д тодорхойлсон АНУ-ын Хэрэглээний Үнийн Индексийг хэлнэ.

“ам.доллар болон \$” гэж Америкийн Нэгдсэн Улсын хууль ёсны мөнгөн тэмдэгтийг хэлнэ.

“Ажлын өдөр” гэж Хөрөнгө оруулалтын гэрээний 16 дугаар бүлэгт тодорхойлсон утгатай ижил байна.

ДЭЭРХИЙГ НОТЛОН, энэхүү Гэрээг Улаанбаатар хотноо **2009 оны 10 дугаар сарын 6-ны өдөр** үйлдэж, гарын үсэг зурав.

Эрдэнэс МГЛ ХХК-ийг төлөөлж:

..... **Б.Энэбиш**
/Гарын үсэг/ Гүйцэтгэх захирал

Айвенхоу Оюу Толгой (БиВиАй) Лтд-ийг төлөөлж:

..... **Жон Фониани**
/Гарын үсэг/ Айвенхоу Майнз Лтд-ийн Хуулийн асуудал хариуцсан гүйцэтгэх дэд Ерөнхийлөгч

Оюу Толгой Нидерланд БиВи-ийг төлөөлж:

Transferor means a Shareholder which proposes to transfer all or some of its Shares in accordance with this Agreement and refers to the Shareholder both before and after registration of the relevant transfer of Shares.

US CPI means US CPI defined in clause 10.3(d)(iii).

USD and **\$** means the lawful currency of the United States of America.

Working Day has the meaning given to that term in Chapter 16 of the Investment Agreement.

IN WITNESS WHEREOF, this Agreement is executed and signed on October 6, 2009 in the city of Ulaanbaatar.

Signed for and on behalf of Erdenes MGL LLC by:

Signature
B. Enebish, Executive Director

Name and Position
6 October 2009
Date

Signed for and on behalf of Ivanhoe Oyu Tolgoi (BVI) Ltd by:

Signature
Peter Meredith, Deputy Chairman, Ivanhoe Mines Ltd.

| | |
|--|---|
| <p>..... /Гарын үсэг/</p> <p>Питер Мередит Айвенхоу Майнз Лтд-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэд дарга</p> | <p>Name and Position 6 October 2009 Date</p> <p>Signed for and on behalf of Ivanhoe Mines Mongolia Inc LLC by:</p> |
| <p>Айвенхоу Майнз Монголия Инк ХХК-г төлөөлж:</p> <p>..... /Гарын үсэг/</p> <p>Кийт Маршал Ерөнхий захирал</p> | <p>Signature Keith Marshall, Managing Director Name and Position 6 October 2009 Date</p> <p>Signed for and on behalf of Oyu Tolgoi Netherlands B.V. by:</p> <p>Signature John Fognani, Executive Vice President Legal and General Counsel, Ivanhoe Mines Ltd. Name and Position 6 October 2009 Date</p> |